

Улсын бүртгэлийн  
дугаар: 015

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн  
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний  
дугаар: ШуГх/ОХУ/-2019/04

## **ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН**

**«ЕВРАЗИЙН ТҮНШЛЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ДАХЬ МОНГОЛ,  
ОРОСЫН СОЁЛ ИРГЭНШИЛ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛ»  
(2019-2022)**

**Гадаадтай хамтарсан төслийн тайлан**

**Гүйцэтгэгч:**

Гэлэгпилийн Чулуунбаатар, төслийн удирдагч  
ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич, доктор (Sc.D), профессор

**Гүйцэтгэгч:** Сампилдондовын Чулуун, академич, доктор (Sc.D), профессор  
Бямбахишигийн Пүрэвсүрэн, доктор (Ph.D), профессор  
Цэнджавын Энхчимэг, доктор (Ph.D), профессор  
Цэвээний Цэцэнбилэг, доктор (Ph.D), дэд профессор  
Ойдовын Хатанболд, ЭШТА, доктор (Ph.D)  
Аюушийн Хишигдаваа, ЭШДЭА, магистр  
Ёндонгийн Ундрал, ЭШДЭА, магистр  
Баасанжавын Ариунзул, ЭШДЭА, магистр

**Захиалагч байгууллага:** Боловсрол, шинжлэх ухааны яам

**Санхүүжүүлэгч байгууллага:** Шинжлэх ухаан, технологийн сан

**Тайлан өмчлөгч:** ШУА-ийн Философийн хүрээлэн

**Гүйцэтгэгч байгууллага:**

ШУА-ийн Филсоофийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбар.

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баруун Сэлбийн гудамж-15, ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн II байр. Шуудангийн салбар-38.

Энэхүү ШуГх/ОХУ/-2019/04 тоот гадаадтай хамтарсан төслийг Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны захиалгаар Монгол Улсын Шинлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт 2019 оны 10 дугаар сараас 2022 оны 12 дугаар сард хэрэгжүүлж гүйцэтгэв.


## РЕФЕРАТ

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбар 2019-2022 онд «Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (ШуГх/ОХУ/-2019/04)<sup>1</sup> сэдэвт гадаадтай хамтарсан төслийг хэрэгжүүлсэн болно.

### Хамтарсан төслийн талаарх ерөнхий мэдээлэл



- Төслийн удирдагч:** Г. Чулуунбаатар, академич, ШУА-ийн дэд ерөнхийлөгч
- С. Чулуун, академич, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал асан
  - Ц. Энхчимэг, доктор (Ph.D), профессор ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн ЭШТА
  - Б. Пүрэвсүрэн, доктор (Ph.D), дэд профессор, ШУА-ийн ФХ-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
  - О. Хатанболд, доктор (Ph.D), ШУА-ийн ФХ-ийн Улс төр-эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА
  - Ц. Цэцэнбилэг, доктор (Ph.D), дэд профессор, ШУА-ийн ФХ-ийн СНСЗС-ын ЭШТА
  - Б. Ариунзул, докторант, ШУА-ийн ФХ-ийн Шашин судлалын салбарын ЭШДЭА
  - А. Хишигдаваа, докторант, ШУА-ийн ФХ-ийн Улс төр-эрх зүйн салбарын ЭШДЭА



**Төслийн удидагч:** А.С. Железняков, доктор (Sc.D), ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн орлогч захирал

- В.А. Родионов, доктор (Sc.D), доцент, ОХУ-ын Буриадын их сургуулийн Дорно дахины хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч
- Т.Н. Литвинова, доктор (Sc.D), профессор, ОХУ-ын МГИМО-ийн Одинцовын салбарын орлогч декан
- В.С. Тихунов, доктор (Sc.D), Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их сургуулийн хүндэт профессор, Газарзүйн факультетийн нэгдсэн зураглалын лаборатори болон Дэлхийн мэдээллийн системийн бүсийн төвийн эрхлэгч

Энэхүү хамтарсан төслийн хувьд Евразийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Монгол, Оросын улс төр, нийгэм - улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох явдал юм. Мөн төслийг хэрэгжүүлэх явцад Оросын болон Монголын соёл иргэншлийн түүх, орчин үеийн байдал гүнзгий, илт тод илэрнэ хэмээн судлаачдын багийн зүгээс үзсэн болно.

<sup>1</sup> Эл төслийн гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр талууд гарын үсэг зурсан болно.


## Хамтарсан төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий мэдээдэл

### Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ

Евроазийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн өнөөгийн байдлыг тодруулсан.

### Тоон ба чанарын судалгаа зохион байгуулах

- Сударга зүйг боловсруулсан (2019.08/09)
- Суд, хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, анхдагч мэдээлэл цуглуулсан (2019.08/09)
- Хээрийн судалгааг зохион байгуулсан (5 аймаг, 6 дүүрэг; 800 орчим респондентд 2019.09/10)
- Мэдээлэлд хяналт хийж, боловсруулсан (2019.09-2020.05).



### Орос, Монголын соёл иргэншлийн түүх, орчин үеийн байдал гүнзгий, ил тод илрүүлэх

XVII-XVIII зууны болон XIX-XXI зуун дахь түүхэн харилцааны асуудлууд, мөн үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгоход улс төр-дипломат харилцаа, геополитик, нийгэм-эдийн засгийн болон соёл, хүмүүнлэгийн хүрээн дэх нийтлэг болон ялгаатай шинж чанар, хандлага төлөвшилийг судлан тодорхойлох оролдлого хийгдсэн.

### Орос, Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох

Евроазийн интеграцийн хүрээнд олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгоход 2 орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжилд тулгарч буй асуудлуудыг тодруулахыг зорив.

«Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (Шугх/ОХУ/-2019/04) сэдэвт гадаадтай хамтарсан төслийн төсвийн мэдээллийг дараах байдлаар танилцуулж байна.

## Төслийн төсвийн мэдээлэл



Хамтарсан төслийн хүрээнд хоёр улсын нийтлэг болон ялгаатай шинжүүд, нийгэм-соёлын хүрээ, улс төрийн үйл ажиллагаа, хүмүүсийн зан төлөв, ухамсартай шууд холбоотой юм. Соёл иргэншлийн ялгаатай хийгээд ижил төстэй талууд, оршин суугчдын чиг баримжаа, хувь хүний улс төрийн зан төлөв, төлөвшилд нөлөөлдөг үндэсний буюу үндэстэн дамнасан нийгэмлэгийн түүхэн болоод нийгмийн баялаг

туршлагад олон нийтийн санаа бодол зэргийг энэхүү хамтарсан төслийн хүрээнд судлан тодруулахыг зорьсон.

Нөгөөтээгүүр, аливаа улс үндэстэн оршин тогтнож, хөгжих явцдаа оюуны болон биет асар их өвийг бий болгож, улмаар хойч үе нь залгамжлан авч явдаг жамтай. Олон үндэстний соёл дотроос оюуны соёл маш чухалд тооцогддог бөгөөд анх философи сэтгэлгээний хүрээнд боловсорсон түүхтэй холбоотой гэж болно.

**«Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (ШуГх/ОХУ/-2019/04)»** сэдэвт гадаадтай хамтарсан төслийн зорилго нь Евразийн интеграцийн хүрээнд олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгохын тулд хоёр орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжилд тулгараад буй асуудлуудыг тодруулах нь гол зорилго болно.

Тус төсөл нь 1990-ээд оноос хойших иргэдийн улс төрийн соёлын төлөвшлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, энэ хүрээн дэх сорилт, бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг улс төр судлалын онол арга зүйн үүднээс судлан боловсруулах, иргэд хоорондын харилцан ойлголцолыг олж тогтоох арга зам, хэлбэр, шийдлийг санал болгож, энэ хүрээний хэтийн төлөв хандлагын талаарх санааг дэвшүүлэн судалгааны эргэлтэнд оруулснаараа онцлогтой.

Бид, **«Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (ШуГх/ОХУ/-2019/04)»** гадаатай хамтарсан судалгааны төслийг хэрэгжүүлэх (2019-2022) хугацаанд гүйцэтгэх үр дүнгийн даалгаварын хүрээнд нийт 21 бүтээгдэхүүнийг нийлүүлсэн. Тэдгээрийг дараах зургаар харуулж байна.

#### **Түлхүүр үг:**

Еврази, Монгол, Оросын соёл иргэншил, нүүдэлчдийн соёл, соёл, төлөвшил, улс төр, улс төрийн үйл ажиллагаа, үйл явц, нийтлэг ба ялгаатай шинж.

## Гарчгийн мэдүүлэг

РЕФЕРАТ .....	2
Оршил.....	6
Нэг. Үндсэн хэсэг: Хамтарсан төслийн зорилго, үндэслэл, хэрэгцээ шаардлага, ач холбогдол .....	8
<i>Суурь судалгааны төслийн зорилго</i> .....	8
<i>Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага</i> .....	8
<i>Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол</i> .....	9
Хоёр. Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэлийг тодорхойлох судалгааны үзэл баримтлал.....	10
Гурав. Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажил, явцын үр дүн, үр дүнгээс гарсан дэвшилтэт талууд .....	24
Дүгнэлт .....	38
Хавсралт 1. Төслийн календарьчилсан төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт .....	41
Хавсралт 2. “Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл” тоон судалгааны үр дүнгийн хүнснэгт .....	77
Хавсралт 3. Олон нийтийн санаа бодлын судалгааны асуулга .....	91
Хавсралт 4. Шинжээчдийн судалгааны асуулга.....	97
Хавсралт 5. Төслийг хамтран хэрэгжүүлсэн байгууллагаас ирүүлсэн албан захидал .	102

## Оршил

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарт хэрэгжсэн «Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (ШуГх/ОХУ/-2019/04) сэдэвт гадаадтай хамтарсан төслийг 2019-2022 онд хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагааны хүрээнд дараахь ажлыг гүйцэтгэв.

Энэхүү хамтарсан төслийн хувьд Евразийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Орос, Монголын улс төр, нийгэм - улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох явдал юм.

Түүнчлэн төслийг хэрэгжүүлэх явцад Орос, Монголын соёл иргэншлийн түүх, орчин үеийн байдал гүнзгий, илт тод илэрнэ. Евразийн интеграцийн хүрээнд олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгохын тулд хоёр орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжилд тулгараад буй асуудлуудыг тодруулах нь гол зорилго болно.

Тус хамтарсан төсөл хэрэгжсэн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааны хураангуй мэдээллийг доорх байдлаар танилцуулж байна.

### Төслийн хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагаа

#### ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, СУДАЛГААНЫ КОНЦЕПЦ БОЛОВСРУУЛАХ

- Хамтарсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгын хүрээнд Орос, Монголын оролцооны үндэслэлийг тодорхойлох;
- Хамтын ажиллагааны хэрэгжилт, хилийн бүсийн нутаг дэвсгэрийг тогтвортой хөгжүүлэх, Евразийн тивийн холбоонд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох хээрийн судалгааг ОН-т зохион байгуулах;
- Сэдэвчилсэн асуудлаар ЭШӨ, ЭШИ тавьж хэлэлцүүлэх.

2021

#### ОРОС, МОНГОЛЫН СОЁЛ ИРГЭНШИЛ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛИЙН ИРЭЭДҮЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- ОНСБ болон шинжээчдийн судалгааны тоон ба чанарын судалгааны үр дүнд тулгуурлан "Орос, Монголын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл: өчигдөр ба ирээдүй" сэдэвт хамтын бүтээлийг бэлтгэж хэвлүүлэх;
- Сэдэвчилсэн асуудлаар ЭШӨ хэвлүүлэх, ОУЭШХ-д ЭШИ хэлэлцүүлэх.

2020

#### ТООН БА ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ НЭГТГЭН ДҮГНЭХ

- Мэргэшсэн екпертийн ба нийслэлийн иргэдийн дунд ОНСБС зохион байгуулах, тайлан бичих;
- "Монголын соёл иргэншлийн өнгө төрх" сэдэвт гэрэл зургын цомог хэвлүүлэх;
- Хамтын бүтээл үзэл баримтлал боловсруулах, хамтын бүтээлийн бичилтийг эхлүүлэх;
- Сэдэвчилсэн асуудлаар ЭШӨ хэвлүүлэх, ОУЭШХ-д ЭШИ хэлэлцүүлэх.

2022 оны  
12 сар

2022 онд төслийн багийн гишүүд Евразийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох зорилгоор судалгааны арга зүй, концепцийг боловсруулахыг зорьсон бөгөөд эл зорилгоо ч төслийн багийн гишүүд биелүүлж чадсан гэж болно.

Энэ зорилгын хүрээнд төслийн багийнхан хамтарсан төлийн эцсийн үр дүн болох «Евразийн бүс нутаг дахь Монгол, Оросын соёл иргэншлийн харилцан үйлчлэл» сэдэвт хамтын бүтээлийг боловсруулан хэвлүүлэв. Хамтын бүтээлд Монгол Улс Төв Евразийн түүхийн бүхий л хугацаанд өнөөгийн аварга хөршүүд болох Хятад, Орос улстай соёл иргэншлийн харилцаатай байж, тэдэнтэй ижил субъект байсны үндсэн дээр тэдэнтэй ямагт эрх тэгш харилцаж ирсэн тусдаа соёл иргэншил. Төв Евразийн орон зайд нэгдсэн Орос, Хятад, Монголын соёл иргэншлийн цөм болох Орос, Хятад, Монголын ангилал зүйн тэнцвэрт байдлын баримтыг хүлээн зөвшөөрсөн нь Орос-Монголын харилцааны сайтар судлагдсан мэт санагдах хуудсыг цоо шинээр харах боломжийг олгож байна. Эрин зуунаас эдүгээг хүртэлх цаг хугацааг тольдон зураглахуйг хичээсэн нь эл хамтарсан төслийн судалгааны гол үнэ цэн, судалгааны ач холбогдол оршиж байна.



Энэхүү хамтын бүтээл нь Орос-Монголын харилцааг Евразийн орон зайн геополитикийн төдийгүй соёл иргэншлийн бүтэц гэсэн хоёр өнцгөөс авч үзэхийг оролдсон болно. Ийм стереоскопоор Монгол Улсын дэлхийн дэг журамд эзлэх байр суурийг Төв Евразийн ард түмний түүхэн хувь тавилангийн олон зуун жилийн гүн гүнзгий сүлжилдсэн үзэгдлийн хэлбэрээр тодруулсан явдал гэж болно. Энэ бол, нэг талаас Орос, Монголын ард түмэн, нөгөө талаас Монгол Хятадын ард түмнүүдийн ялгаатай шинжүүдийг тандан судлахыг чухалчлав. Мөн Төв Евразийг түүхэн Монгол, түүхэн Орос, түүхэн Хятад зэрэг өргөн уудам нутаг дэвсгэрт амьдардаг ард түмний нийтлэг орон зай гэж ойлгох болох талаарх үндэслэлийг тодруулав. Бүтээл 5 бүлэг, 15 зүйл, өмнөтгөл, дүгнэлт, товч хураангуй, ном зүйн хэсгээс бүрдэнэ. *Хэвлэсэн газар: «Соёмбо принтинг». ХХК. Уб., 2023. 32хх. Зохиогчид: Чулуунбаатар Г., Железняков А.С., Чулуун С., Энхчимэг Ц., Хатанболд О., Цэцэнбилэг Ц., Родионов В.А., Дамдин Д.Б., Литвинова Т.А. Редакцийн зөвлөл: Чулуунбаатар Г., Железняков А.С., Хатанболд О.*



## Нэг. Үндсэн хэсэг: Хамтарсан төслийн зорилго, үндэслэл, хэрэгцээ шаардлага, ач холбогдол

### *Суурь судалгааны төслийн зорилго*

«Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (ШуГх/ОХУ/-2019/04) сэдэвт гадаадтай хамтарсан төслийн зорилго нь Евразийн интеграцийн хүрээнд олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгохын тулд хоёр орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжилд тулгарч буй асуудлуудыг тодруулахад оршино.

### *Төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага*

Монголчууд болон Өвөр Азийн бусад ард түмнүүдийн хувьд нийтлэг өвөг дээдэс чухам хэн бэ? Тэд бол Ази Европын асар том орон зайгаар хүрээлэгдсэн Өвөр Азийн өргөн уудам бүс нутагт амьдрал цогцлоосон нүүдэлчдийн эзэнт гүрнийг үндэслэгчид мөн. Өнөөгийн монголчуудын хувьд аж төрөх орчин нөхцөлөө бүрдүүлэх, эх орныхоо аюулгүй байдлыг хангах арга ухаан чухамдаа цаг үргэлж л өвөг дээдсээсээ авч байв. Харин тэдний Монгол эх орон бол хүн амд ногдох байгалийн нөөц баялгийн цар хүрээгээрээ дэлхийн хамгийн баян улсын нэг юм. Энэ байдлаа зохистой ашиглахын тулд Орос, Хятад улсаар гадаад хил хязгаар нь тэлж буй Өвөр Азийн бүс хэмжээнд төдийгүй энэ зааг хязгаараас хол давсан Евроазийн бусад бүс нутагт аюулгүй байдал, олон талын харилцаагаа бэхжүүлэх шаардлагатай гэдгийг түүхэн баримтууд харуулж байгаа билээ.

Өнөө үед Еврази бүхэлдээ, түүний дотор Орос, Монгол, Хятадын сайн хөршийн харилцааг бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах хүчин чармайлтын хэтийн төлөв итгэл найдвар төрүүлсэн байдалтай байна. Түүхэн туршлагаас үзэхэд, мөнхийн хоёр том хөрш Орос, Хятадын хүчин чармайлт хангалттай биш гэдэг нь тодорхой болсон бөгөөд одоо үүсээд буй нааштай хэтийн төлөвийг түүхэн хөгжлийн бүтээлч субъект болсон нүүдэлчдийн сонгодог уламжлал бүхий Монгол Улсын идэвхтэй оролцоотой холбох нь нэн чухал юм.

Үнэнийг хэлэхэд энэ тухайд орчин үеийн монголчууын үүрэг хангалтгүй байна. Чухамдаа тэд XIII зууны үед Их Монгол Улсын төвөөс өвөг дээдсийн эхлүүлж, улс төрийн сэдэл өгсөн анхны даяаршлын ялалтыг давтах зорилттой тулгарснаар цаг алдалгүй бүх орон зайг хамруулан практик ажиглалт хийж, энэхүү бодлогыг дэлхий дахинд бодиттойгоор хэрэгжүүлэх шаардлагатай болж байна. Өвөг дээдсийн аливаа үйлдлийг хуулбарлах боломжгүй. Эл дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд аливаа дайн түрэмгийлэлгүйгээр тайван замаар хүрэх ёстой.

Орос-Монгол-Хятад гурван улсын Эдийн засгийн коридорын албан хэлбэрийн талаар харьцан хүлээн зөвшөөрсөн нь Монголын ойрын хөршүүд ийм ирээдүйн хөгжилд аль хэдий нь бэлэн байгааг харуулав. «Гурав дахь хөрш» гэж хамтатган нэрлэгдэх АНУ, Баруун Европын улсууд, Япон, Энэтхэг болон бусад дэлхийн

томоохон тоглогчид Монгол Улстай стратегийн түншлэлийн харилцаа тогтоож, бэхжүүлэх сонирхол илэрхий идэвхжиж байна.

Монгол бол өвөг дээдсийн түүхэн үеэсээ тооны олноор биш, ур чадвараар үйлддэг ард түмэн. Үүнд л амьдралын наад захын арга хэрэгсэл бүхий цомхон жижиг багийн хүчээр тавьсан зорилгодоо хүрдэг монгол соёл иргэншлийн «цөм» («ганц үзэм») болсон гол онцлог оршино.

*Суурь судалгааны төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол*  
Даяаршил, иргэншил хоорондын харилцан үйлчлэл эрчимтэй өрнөж буй өнөөгийн эрин үед хүн төрөлхтний ирээдүйд юу тохиолдож болох талаар эрдэмтэн судлаачид сонирхолтой санаа дэвшүүлсэн цөөн биш бүтээлүүд гарсныг бид мэднэ.

Эл судалгааг хэрэгжүүлэх, судалгааны мэдээллийн үндсийг бүрдүүлэх гол туршилт сорилтын түшиц бааз нь өрнөж буй улс төрийн үйл явдлуудын хэмжээнээс үзэхэд, зуугаад жил үргэлжилсэн соёл иргэншлийн ээлжит хугарлаас Монгол Улс өнөөдөр удаан гарч байгаа бөгөөд тэр хэмжээгээр шинэ үе шатанд удаашралтай дэвшиж байна. Энэ бол шинэ замын эхийг тавихын тулд бүтээлч шинэ санаачилга шаардлагатай болохыг харуулж буй явдал юм.

Даяаршил эрчимтэй өрнөж, цахим технологи үсрэнгүй хөгжиж буй өнөө үед дэлхий дахиныг нэгэн зэрэг хамарсан үйл явц маш богино хугацаанд өргөх боломж бүрдсэн ийм нөхцөлд «*бүх нийтийн даяаршсан улс төр*» хэмээн нэрлэж буй үзэгдэл дэлхийн янз бүрийн улс орны үндэсний соёл иргэншлүүдэд ямар нөлөө үзүүлж байгааг судлах нь шинжлэх ухааны хувьд сонирхолтой төдийгүй соёл иргэншлийн аюулгүй байдал, түүний цаашдын зохистой хөгжлийн чухал хүчин зүйл болсныг ташрамд тэмдэглэе.

Монгол Улс бүс нутгийн болон гео-политикийн өвөрмөц байрлалаараа дэлхийн соёл иргэншлийн сүлжээ, соёл иргэншлийн төв хийгээд туйлуудын харилцан хамаарал, харилцан нөлөөлөлд чухал үүрэгтэй. Өнөөдөр Монгол Улсын багтаж буй Зүүн Ази, Өвөр Азийн болон Евразийн бүс нутгийн соёл иргэншлийн сүлжээ дэлхийн хөгжлийн шинэ хандлагад үлэмж нөлөөтэй болох хандлага өрнөж байна. Тэгэхлээр дэлхийн хөгжлийн шинэ хандлагаар нэг туйлт байдлаас хоёр гурав, олон туйлт хөгжлийн төлөвт шилжиж буй байдал, энэ хандлагад бүс нутгийн хөгжил хэрхэн нөлөөлж буй, улмаар энэ нөлөөлөл үндэсний соёл иргэншлийн хувь заяаг хааш нь эргүүлэх бол гэдэг асуудал бол Монгол соёл иргэншлийн судалгааны нэн чухал сэдвүүд мөн. энэ зорилтын хүрээнд судалгааны үр дүнгээр хамтын бүтээл гаргах зорилт тавьж ажилласан болно.

## Хоёр. Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэлийг тодорхойлох судалгааны үзэл баримтлал

Еврази тивийн төвд оршдог Өвөр Азийн түүхэн олон соёлын өргөн бүс нутаг нь Монголын хязгаараас халин гарч дэлгэрдэг бөгөөд газар зүйн хувьд түүний стратегийн хөршүүд Орос ба Хятадын нутаг дэвсгэрийн гүнд нэвтрэн ордог. Монгол хэлтэй ард түмнүүд болон тэдэнтэй шашин соёлын хувьд төрөл нэгтэй бусад ард түмний Монгол, Орос, Хятадад оршин амьдардаг нутаг дэвсгэр нь Транс-гимлай, Хархорин болон говиос эхлээд Хангай, Хэнтий болон Байгалийн чанадыг хүртэл, Хянганаас эхлээд Саяны болон Алтайг<sup>2</sup> хүртэлх бүсүүдийг байгаль цаг уурын болон түүх соёлын асар том тархай байдлаар тодорхойлогддог билээ.

Монголд болон түүний хилийн гадна янз бүрийн газарт оршин амьдардаг эдгээр ард түмэн түүхийн нийтлэг ерөнхий ой санамж, шашин, соёлоор гагнагдсан байдаг бөгөөд тэр нь тэдний соёл иргэншлийн хувьд төрөл нэгтэй болохыг гэрчилдэг. Энэ нь олон улсын харилцааны тогтолцоонд эрс өөрчлөлт гарсан өнгөрөгч зууны сүүлчийн хорин таван жилд онцгой илэрхий болсон билээ. Эдгээр өөрчлөлт нь нийгмүүдийн хоорондын зарим нэг улс төрийн саад бэрхшээлийг устгасан, тэдгээрийг өөр нийгмээр сольсон, улс орнуудын хилийн, дэлхийн болон бүс нутгуудын төвүүдийн нөлөөний хүрээний, нийгмүүдийн өөрсдийн нь ерөнхий дүрсүүдийн өөрчлөлтүүдийн үйл явцыг судлах түүхчид, улс төр судлаачдын сонирхол улам өсөх явдлыг хөхүүлэн дэмжиж өгсөн. Өнөө цаг үе шинэ бүрэлдэн буй туйлт дэлхийн байгууламжийн субъектүүдийн социал-түүхийн хувьслын үйл явцуудыг онлайн дэглэмээр болон янз бүрийн үзлийн үүднээс судлах өвөрмөц ховор боломжийг олгож байна.

Өнөөгийн олон туйлт дэлхийн байгууламж дахь Монголын туйлыг түүх-соёлын томоохон нэгтгэлүүд-соёл иргэншлүүд ард нь байдаг бусад туйлуудын глобал хүрээтэй хосолсон түүний нөлөөг глобал хүрээтэй нь хамт илрүүлэхтэй холбоотой юм. Дэлхий дээрх Монголын байр байдал, үүргийг эдийн засаг, улс төрийн нөлөөний дэлхийн төвүүдийн өөр хоорондын харилцааны мөн тогтолцооны хүрээнд авч үзэж судлах нь глобал улс төрийн хүчнүүдийн хуваарилалтыг ойлгох ойлголтын зарим нарийн төвөгтэй асуудлыг тодруулан тайлбарлахад туслах болно. Энэ нь харьцангуй хүн ам цөөтэй улс орнуудын дотор Монгол нь олон талаар өвөрмөц ховор орон болохтой холбоотой юм. Соёл иргэншлийн параметруудээрээ түүнтэй ойролцоо бие даасан тусгаар улс орон дэлхийд хэрэг дээрээ байдаггүй. Гэвч түүний хөрш орнуудад хэл соёл, шашнаараа монголчуудтай төрөл нэг цөөн тоотой ард

---

<sup>2</sup> Рерих Н.Ю энэ бүс нутгийн газар зүйн хязгаарыг гойд сайхан тэмдэглэсэн байдаг. Үүнд: «гадаад далайд гарцгүй Өвөр Азийн асар том хэсэг нь өмнөд талаараа хүчирхэг Транс-гималай болон Хархорины дунсгэр уул нуруудаар хязгаарлагддаг, Хойт Алтайн нуруу болон Сибирийн өмнөд хязгаарын цагирагласан уул нурууд хүрээлдэг. Энэ асар том хуурай газрын зүүн болоод баруун талаар Монголын Их Говийн болон Дундад Азийн тал нутгийн зах хязгааргүй өргөн уудам хоосон тал цэлийдэг» гэжээ. (Рерих Ю.Н. По тропам Срединной Азии. Самара: Агни, 1993. с. 4).

түмэн, угсаатны бүлгүүдтэй олон зуунаар айл хөрш байснаараа ойролцоо юм. Юун түрүүнд, энэ бол буриадууд, тувачууд, өвөр монголчууд бөгөөд тэдгээр нь Оросын болон Хятадын зүгээс Өвөр Азид нутагладаг оросууд болоод хятадууд, алтайчууд, якутчууд, казахууд, эвенкчүүд, уйгурууд, төвдүүд зэрэгтэй цааш цаашид холбоотой байдаг. Өвөр Азийн гадна Повольжид бас өөрийн хөршүүдтэй халимагийн анхлав оршдог. Эдгээр ард түмнээрээ болон угсаатны бүлгүүдээрээ, тэднийхээ дэлхийн диаспораараа (Дэлхийн энх тайвны шагналт, XIV Далай лам тэргүүтэй Төвдийн диаспорыг оролцуулаад) дамжуулан, мөн тэрчлэн Евразийн улс төрийн түүхэнд Монголын үлдээсэн ул мөр болон орчин үеийн гадаад бодлогоор нь дамжуулан хойд буддын шашны болон тэнгэр шүтлэгтэй Өвөр Азийн ертөнц Өмнөд Энэтхэг-буддын ертөнц Христосын, Күнзийн, исламын ертөнцүүдийн соёл иргэншлүүдийн өргөн уудам орон зайтай тогтоосон холбоо харилцааны тогтолцоонд жинтэй бөгөөд тусгаар байр байдалтай байдаг.

Монголын өөрийнх нь хувьд орчин үеийн ертөнцөд өөрийн байр байдлаа тодорхойлох нь тун чухал асуудал юм. Учир нь түүнийг «*өөрийн*» болон «*гаднын*» гэсэн шатлалаар «*дээрээс*» ердөө хаана ч бичиж тэмдэглээгүй. Уг нь бүхлийг төлөөлж буй хэсгүүдийн хувьд олон туйлт, хоёр туйлт, нэг туйлт дэлхийн аль ч байгууламжийн нөхцөлд энэ нь зайлшгүй болох ёстой зүйл л дээ. Харин зөвхөн Орос болоод Хятад оронтой хиллэдэг, дэлхийн соёл, шашин, соёл иргэншлүүдийн уулзварын өвөрмөц ховор нутаг дэвсгэрийн нэг болох Өвөр Азийн төвд оршдог орон болох Монгол Улсын гадаад улс төрийн идэвхжил нь дэлхийн орчин үеийн улс төрийн газрын зураг олон туйлт бүтээц байдаг, тэр талд ашигтай нэмэлт нотолгоо болж өгөх болно.

Улс төрийн энэ идэвхжилийн соёл иргэншлийн өвөрмөц байдал нь хүчний ямар нэгэн ганц гадаад төвд хамаатуулах боломжгүйгээр илэрч байдаг бөгөөд улс төрийн дэлхийн байгууламжийн субъектүүдийн социал-түүхийн харилцан үйлчлэл болон сүлжилдсэнийг судалдаг улс төрийн шинжлэх ухааны онцгой салбар болох соёл иргэншлийн улс төр судлалын дам судалгаагаар харагдаж байна. Соёл иргэншлийн улс төр судлалын хандлага нь дэлхийн байгууламжийг үзэх түр зуурын, дуу дуугаа авалцсан үзэл биш бөгөөд тиймээс түүнийг анхнаасаа, тогтмол олон туйлт байсныг хүлээн зөвшөөрдөг. Энэ хандлага нь газарзүйн байршил, түүхэн туршлага, нөөц баялаг, эдийн засаг ба зэвсэгт хүчний боломжийг үнэлэн, орчин үеийн улс гүрнүүд ба гүрнүүдийн блокуудыг синхроноор харьцуулдаг геополитикийн хандлагаас ялгаатай. Зөвлөлтийн эвсэл нуран унасны дараагаар эвслээс ангид шинэ Монгол Улс дэлхийд байр байцаа олон явдал геополитикийн сонгодог хандлагуудаас татгалзахгүйгээр боломжгүй юм. Тийм татгалзал үгүйгээр Монголыг хоёр аварга гүрний хооронд бамбай улсын байдалтай байсан ХХ зууны эхний хагасын танил байдлаас өөрөөр төсөөлөх боломжгүй билээ. Гэвч ХХI зуунд НҮБ-ын гишүүн улс Монголыг хөөгдсөн байдалд оршдог бамбайн улсын хувиар төсөөлөх нь утгагүй хэрэг билээ. Өнөө цаг үе дэлхийн байгууламжийн субъектүүдийн улам өсөн нэмэгдэж буй харилцан хамаарлаар тодорхойлогдож байгаа бөгөөд бамбайн болон алх дөшний хооронд дахь үенцэрийн геополитикийн болхи бүдүүлэг дүр төрхийн оронд их, бага, бүх тэргүүлэгч зангилаанууд («араанууд») адилхан чухал утга

холбогдолтой байдаг соёл иргэншлүүдийн дэлхийн хамтын нийгэмлэгийн үйлчлэлийн нарийн (бараг цагийн зүү шиг шахуу) механизмын дүр зураг гарч ирэх зайлшгүй шаардлага өөрийн эрхгүй тулгараад байна.

Энэхүү дүр зураг гурван сая гаруй хүн амтай, өөрөөр хэлбэл, түүний хөршүүдтэй харьцуулбал тун өчүүхэн, түүнээс эрс ялгаатай хоёр аваргуудын хооронд хавчигдсан, гэхдээ ямар боловч гурван орны нутаг дэвсгэр дээр оршдог локаль соёл иргэншлийн төв хэсэг, тэргүүлэгч зангилаа нь болдог Монголын хувьд илүү тохиромжтой юм.

Соёл иргэншлийн хандлага нийгэм судлалын харьцангуй шинэ салбар болох цивилиограф (соёл иргэншлүүдийн тухай шинжлэх ухаан)-тай холбоотой бөгөөд тэр нь юуны өмнө энэ шинжлэх ухааны үндэслэгчид болох Н.Я.Данилевский<sup>3</sup> (1822-1885), О.Шпенглер<sup>4</sup> (1880-1936), болон А.Ж.Тойнби<sup>5</sup> (1885-1975) нарын нэртэйгээр сэтгэлд буудаг. Мэдээж соёл иргэншлийн шинжлэх ухааны эх сурвалжууд эдгээр эрдэмтдийн бүдүүвч зургуудаар хязгаарлагдахгүй.<sup>6</sup> Эдгээр схемүүд нь өнгөрөгч үеийн болон одоо цагийн сэтгэгчдийн гаргасан дэлхийн байгууламжийн бусад дүр зураг, «соёл иргэншил» гэдэг ойлголтын агуулгыг тайлбарласан тайлбаруудтай холбоотой билээ.

Соёл иргэншлийн хандлагыг үндэслэгчдийн зурагласан дэлхийн байгууламжийн схемийг орчин үеийн болгоход Питирим Сорокин (1889-1969) гавъяа байгуулсан хүн. Тэрбээр дэлхийн түүхийн болон орчин үеийн дэлхийн байгууламжийн морфологи (бүтцийн зүй)-ийн нэгтгэсэн дүр зургийг бүтээхэд жинтэй хувь нэмэр оруулсан юм.<sup>7</sup> Чухамдаа тэрбээр Н.Я.Данилевскийн соёл-түүхийн хэв маягууд, О.Шпенглерийн дэлхийн зургийн чиг үүргүүд болох сэтгэлийн зургууд болон А.Ж.Тойнбигийн Өдөлт-ба-Хариу гэгч бүтээц (ихээхэн нэр хүндтэй, гэвч хийсвэрээр, санаанаас) зохиосон гурван схемийг нэгтгэн холбосон юм.

Соёл иргэншлийн асуудал эдүгээ ч соёл иргэншлийн хандлагуудыг үндэслэгчдийн эдгээр «санаанаасаа зохиосон», жаахан өөрчлөгдсөн байх схемүүдийн нэгтгэсэн дүр зураг дээр үндэслэгддэг (суурилдаг) болой. Бараг санаанаасаа зохиосон, өөр хоорондоо холбогдсон схемүүд нь өвөрмөц содон санагддаг бөгөөд орчин үеийн түүхчид болон улс төр судлаачид соёл иргэншлийн хандлагын хэрэгслийг нийгмийг судлах судалгааны үр нөлөөтэй зэвсэг (хэрэгсэл) болгон амжилттай ашиглаж байна.

<sup>3</sup> Данилевский Н.Я. Россия и Европа. Взгляд на культурные и политические отношения славянского мира к германо-романскому. М.: Эксмо, 2003.

<sup>4</sup> Шпенглер О. Закат Европы. Очерки морфологии мировой истории. 1: Гештальт и действительность / Пер. с нем., вступ. статья и примеч. К.А.Свасьяна. М.: Мысль, 1993.

<sup>5</sup> Тойнби А.Дж. Постигание истории. Сборник / Пер. с англ. М.: Прогресс, 1991.

<sup>6</sup> Соёл иргэншлийн шинжлэх ухааны эх сурвалжуудын задлан шинжилгээг дараах даацтай бүтээлүүдээс үз.

Үүнд: Кузык Б.Н., Яковец Ю.В. Цивилизации: теория, историа, диалог, будущее. В. 2 т. М.: Институт экономических стратегий, 2006, Ионов И.Н., Хачатурян В.И. Теория цивилизаций от античности до конца XIX века. СПб.: Алетейя, 2002.

<sup>7</sup> Sorokin P.A. Sociological theories of today. N.Y.-L.: Harper and Row, 1966.

Түүхийг үзэх социал-философийн дээж бичгийн энгийн энэ өв уламжлалыг орчин үеийн судлаачдын хөгжүүлсэн бааз суурин дээр эдүгээ дэлхий ертөнц хэд хэдэн (таваас арав хүртэл, түүнээс жаахан олон) соёл иргэншлээс бүрэлдсэн байдлаар төсөөлөгддөг. Жишээ нь, Хантингтоныхоор (мэдлэгийн энэ салбарт энэ зохиогчийг эдүгээ нэн олонтоо иш татдаг) 1990-ээд оноос хойш дэлхий ертөнц дараах 6,7,8 буюу 9-н «гол» соёл иргэншлийг тухайлдаг байна. Үүнд: Барууны, Лалын, Хятадын, Энэтхэгийн Үнэн алдартны, Японы, Буддын, Латин – Америкийн, Африкийн, эдгээр юм (сүүлийн хоёр гурвын тухайд зохиогчид зарим нэг эргэлзээ байдаг).<sup>8</sup>

Монголын нүүдлийн нийгмийн тухайд гэвэл дэлхий дэх түүний байр болон дэлхийн байгууламжийн бусад субъектүүдтэй түүний социал-түүхийн харилцан нөлөөллийн янз бүрийн талуудыг хамгийн анх Монголын өөрсдийн нь нүүдэлчдийн дотроос гарч ирсэн сэтгэгчид өөрсдийн бүтээлүүддээ тусгасан байдаг. Зохиогчийн нэргүй боловч он дарааллын бичгүүд, мөн тэрчлэн Цагаан Цэцэн (XVII зуун), Лувсанданзан (XVII зуун) Дамбадорж (XIX зуун) Эрдэнэпил (1887-1960) зэрэг (тэдний олонх нь буддын лам нар байсан) томоохон эрдэмтдийн бүтээлүүд бол түүхийн бүтээлийг туурвихад эх сурвалж болдог төдийгүй, тэдгээрийг Монгол нь улс төрийн субъект чанартай болох сэдвийг судлахын тулд орчин үеийн аналитик өгөгдөхүүн болгон ашиглаж бүрнээ болно.<sup>9</sup>

Орчин үеийн улс төр судлалын хувьд эдгээр он дарааллын бичгийн ач холбогдол нь нэг талаас Монголын зохиогчид зөвхөн тэдэнд олж үзэх боломжтой байсан тухайн үеийн баялаг материалд тулгуурлан Монголын нүүдлийн нийгмийн генезис, түүний бүтэц, дотоод болон гадаад улс төрийн харилцааны асуудлууд, дэлхийн байгууламж дахь түүний тархалт, байр байдлыг авч үзсэнээр, гэвч, нөгөө талаас, нүүдлийн амьдрал, тэнгэр шүтээн, хойт (төвд) буддизмын янз бүрийн сургуулиудын гүн ухааны ойлголт, категориудтай холбоотой өвөрмөц онцгой үг хэллэгүүдийг тэдгээр бүтээлүүдэд хэрэглэж байснаас болоод тэдний хийсэн бүрнээ үнэн зөв дүгнэлтүүд нь одоо хүртэл шинжлэх ухааны мэйнстрим (тэр ч байтугай тэдний бүтээлүүд цивилиографийн эх сурвалжуудын энгийн жагсаалтад ороогүй)-д нэгтгэгдэж тусгагдаагүй явдлаар тайлбарлагддаг билээ.

Синкретик шашин буюу тэнгэр шүтээний инструментар нь нэн өвөрмөц зүйл юм. Түүнийг Өвөр Азийн нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан ард түмнүүд өөр шашинд, тухайлбал, тусдаа буддын шашинд буюу даогийн шашин болоод күнзийн сургаал, христийн болоод исламын шашинтай цогц байдлаар эцэслэн хандах хүртлээ эрт дээр үеэс шүтэж байсан юм. Энэ бол нүүдлийн нийгмийн үндсэн шүтээнтэй (юуны өмнө Мөнх Тэнгэр шүтлэгтэй) холбоотой энэ тэр шашны

<sup>8</sup> Хантингтон С. Столкновение цивилизаций. М.: АСТ, 2003. С.22-23.

<sup>9</sup> Шара туджи. Монгольская летопись XVII века. / Сводный текст, пер., введ. и примеч. Н.П.Шастиной. М. -Л.: Изд-во АН СССР, 1957; Лувсан Данзан. Алтан тобчи (Золотое сказание) / Пер.с монг., введ., комментарий и приложения Н.П.Шастиной. М.: Наука, Восточная литература, 1973; История в трудах ученых лам / Сост. А.С.Железняков, А.Д.Цендина. М.: Товарищество научных изданий КМК, 2005 (уг номонд нэргүй зохиогчийн «Алтан товч», Жамбалдоржийн «Эрдэнийн эрх», Эрдэнэпилийн «Конечная причина религий в Монголии» (Монгол аймгуудад шашин хэрхэн үүссэн) бүтээлүүд орсон байдаг.

элементүүдийн аль нэг цаг үеийн янз бүрийн хослолтой мөнх тэнгэр шүтээн ноёрхсон өвөрмөц матриц юм.

Өнөөгийн Монголд энэхүү матриц өнгөрсөн эрин үеүдийнх шигээ шашны хөгжлийн үндсэн чигийг тодорхойлж байна. Улс орны өдөр тутмын амьдралд Чингис хааны нэрний улам бүр өсч буй үүргийг харгалзан энэ матрицын нөлөөг зөвхөн шашны хүрээгээр хязгаарлаж болохгүй.

Бүхэлдээ Монголын зохиогчдын бүтээлүүд, юуны өмнө XIII зууны агуу гайхамшигтай дурсгал болох «Монголын Нууц Товчоо»<sup>10</sup> өнө удаан хугацаанд ховор нандин мэдээллийн үндсэн эх сурвалж болж байсан бөгөөд түүнийг суурин амьдралд хэвийн хэрэглэгддэг категориудын үзэл санаагаар дахин сэтгэх шаардлагатай байжээ. Тэгэхийн хамт суурин ертөнцийн төлөөлөгчид, тухайлбал, күнзийн, христийн болон исламын зохиогчид болох Сыма-Цянь, Плано Карпини, Гильом Рубрук, Марко Поло, Жувейн, Рашид-ад-дин зэрэг эрдэмтдийн нүүдэлчин ёсонд хандах дээрхээс дутуугүй давтагдашгүй ховор, өвөрмөц аналитик хандлагууд судалгааны давамгайлах урсгалуудад шингэн оржээ.<sup>11</sup> Эдгээр төлөөлөгчдийн хандлагыг нүүдэлчин ертөнцийн төлөөлөгчид хачин, ховор хандлага гэж үзнэ. Урт удаан хугацааны туршид түүхийн философийн нүүдэлчний болон төв суурины салаа мөчрүүдийн хоорондын, тэрчлэн улс төр судлалын суурь дахь ялгаа зааг улам гүнзгийрчээ.

Энэ нь соёл иргэншлийн хандлагыг үндэслэгчдийн зүгээс монголчуудын нүүдлийн ёс, нүүдлийн ертөнцөд хандах хандлагад илэрлээ олсон байдаг. Н.Я.Данилевскийн хувьд монголчууд нь «Түүхийн сөрөг бүтээгчид»<sup>12</sup>, О.Шпенглерийн хувьд монголчууд бол тэдний эрин үетэй тэр бээр «органик бус зүйл рүү, төгсгөл рүү хийсэн айхтар муухай алхамыг»<sup>13</sup>, жишээлбэл, «арабын соёлын төгсгөлийг»<sup>14</sup> холбодог тийм эриний хүмүүс аж, А.Ж.Тойнбийн хувьд нүүдлийн ёс бол онцгой, сөнөсөн соёл, соёл иргэншил байдаг бөгөөд тэр нь үүссэнийхээ дараагаар өөрийн хөгжилдөө зогсон саатаж, хөшин царцаж устсан<sup>15</sup> аж.

Чингэхийн хамт, түүхийн нүүдлийн философи тархалтынхаа хүрээг газар тариалан эрхлэх, хотын соёл дэлгэрэхийн хирээр улам хумьж, европ төвтэй, бүр нарийндаа бол төв суурины шинжлэх ухааны мэйнстрим баруун европын, хятадын, төвдийн,

<sup>10</sup> Козин С.А. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г. М.-Л.: Изд-во АН СССР, 1941.

<sup>11</sup> Сыма Цянь. Исторические записки. М.: Восточная литература, 1972; Рассказы русских летописей. М.: Витязь, 1993; Армянские источники о монголах. Извлечения из рукописей XIII-XIV вв. М.: Восточная литература, 1962; Плано Карпини Дж. дель. История монголов. 3-е изд, Гильом де Рубрук. Путешествие в восточные страны. 3-е изд; Книга Марко Поло. 4-е изд. М.: Мысль, 1997; Рашид-ад-дин. Сборник летописей. М.-Л.: Изд-во АН СССР. Т. I. Кн. 1, 2. 1952; Т. II. 1960; Т. III. 1946; Вернадский Г.В. О составе Великой Ясы Чингисхана. С приложением главы о Ясе из истории Джувейни в переводе В.Ф.Минорского. Bruxelles: Les Editions Petropolis, 1939 и др.

<sup>12</sup> Данилевский Н.Я. Россия и Европа. Взгляд на культурные и политические отношения славянского мира к германо-романскому. М.: Эксмо, 2003.

<sup>13</sup> Там же. С. 165.

<sup>14</sup> Шпенглер О. Закат Европы. Очерки морфологии мировой истории. 1: Гештальт и действительность. М.: Мысль, 1993. С. 196.

<sup>15</sup> Тойнби А.Дж. Постигание истории. Сборник / Пер. с англ. М.: Прогресс, 1991. С. 181, 725.

арабын, персийн болон оросын зохиогчдын онолын боловсруулалтыг улам илүү хамрах болжээ.

Оросын шинжлэх ухааны дэг сургууль I Петр хааны 1700 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн зарлигаар Бээжинд байгуулсан Оросын Шашны төлөөлөгчийн газрын судалгаа шинжилгээний үйл ажиллагаанаас эхлэн Манжийн Чин эзэнт гүрний ард түмнүүдийг (түүний бүрэлдэхүүнд Монгол 10 жилийн өмнө багтаж орсон байдаг) үнэн алдартны шашинд хандуулах зорилготой анхдагч, зам гаргагч нь болсон юм. Түүний гүнзгийрүүлэн судлах ажиллагаа XIX зуунаас эхэлсэн<sup>16</sup> билээ. Тэр үед л анхлан Монголыг улс төрийн анхаарлын объект, орос хүмүүсийн хувьд эзэмшихэд тохиромжтой нутаг дэвсгэр бүхий «ашиглаагүй байгаа нөөц баялгийн уурхай» хэмээн бичжээ.<sup>17</sup> Тэр цагийн болон түүнээс бүр хожуу үеийн ийм дүгнэлтүүд хийсэн зохиогчдын толгойд ч хүртэл нүүдэлчид энэ нөөц баялгийг ашиглаж байсан тухай санаа орж ирэхгүй байжээ. Тэдний хувьд газар тариалангийн бус амьдралын хэв маяг ингэж үл ойлгогдом байжээ. «Улс орныг удирдах уламжлалт байгууллагуудын хоцрогдолд<sup>18</sup>» хандах европ төв үзлийн хандлага Хиагтаас Бээжин хүртэл 10 дахь Шашны төлөөлөгчийг ГХЯ-ны түшмэлийн хувиар дагалдан явсан Е.Ф.Тимковскийн 1824 онд хэвлүүлсэн «Путешествие через Монголию и Китай в 1820-1821гг» (Монголоор дамжин Хятадад 1820-1821 онд зорчсон нь) гэсэн өдрийн тэмдэглэлд бүр ч илүү тод харагддаг. Тэгэхийн хамт дэлхийн байгууламж дахь Монголын байр байдал Монголыг Орос Хятадтай нөлөөгөө хуваадаг орон зай хэмээн үзсэн Н.Я.Бичурины үзэл 1828 онд толилуулсан «*Монголын тухай тэмдэглэлүүд*»-д хангалттай нарийн тусжээ.<sup>19</sup>

Дэлхий дээрх Монголын улс төрийн байдлын талаарх Оросын судалгаа XIX зууны хоёрдугаар хагаст мэдэгдэхүйц идэвхжээ. Энэ нь Орос улс өөрийн байр сууриа Дорнод Азид хүчтэй болгох гэсэн түүний эрмэлзэлтэй холбоотой байв. Тэр нь улс төрийн санаа бодлын квинтэссенци (дээж) болох Орос Хятадын XIX зууны хэд хэдэн гэрээнд тусгалаа олжээ. 1858 оны Айгунын болон Тяньцын гэрээнүүд, 1860 оны Бээжингийн гэрээ, 1881оны Петербургийн гэрээнд Чин улсын эзэнт гүрний хил орчмын (Умард, Өмнөд Монголыг оролцуулаад) районуудад худалдаа арилжаа хийх Оросын иргэдийн эрхийг өргөжүүлэх тухай зүйл заалтуудыг тус тус оруулж, хил орчмын районууд дахь оросын харьяат иргэдийн чөлөөт худалдааны үйл ажиллагааны хязгаарлалтуудыг арилгажээ.<sup>20</sup> Асуудлын геополитикийн талтай XIX зууны хоёрдугаар хагаст XX зууны эхний үеийн оросын нэрт жуулчид, судлаачид болох Н.М.Пржевальский, Г.Н.Потанин, А.М.Позднеев, К.Г.Э.Манхергейм, П.К.Козлов<sup>21</sup> нарын Өвөр Азийн бүс нутгаар аялсан алдартай экспедицүүд

<sup>16</sup> Веселовский Н.И. Материалы для истории Российской духовной миссии в Пекине / под ред. Н.И. Веселовского. Вып. I. СПб., 1905. С. 15.

<sup>17</sup> Путешествие архимандрита Софрония Грибовского от Пекина до Кяхты в 1808 г. // *Сибирский вестник*. 1832. Ч. 1. С. 43, 46.

<sup>18</sup> Тимковский Е.Ф. Путешествие в Китай через Монголию в 1820 и 1821 гг. Т. 1-3. СПб., 1824. С. 6-7.

<sup>19</sup> Бичурин Н.Я. (Иакинф). Записи о Монголии, сочиненные монахом Иакинфом. Т. 1-2. СПб., 1828. С. 51-58.

<sup>20</sup> Гримм Э.Д. Сборник договора и других документов по истории международных отношений на Дальнем Востоке (1842-1925). М., 1927. С. 55, 56, 72, 86.

<sup>21</sup> Пржевальский Н.М. Монголия и страна тангутов. Трехлетнее путешествие в Восточной нагорной Азии. Т. 1, 2. СПб., 1875-1876; Потанин Г.Н. Очерки Северо-Западной Монголии. Вып. 1-4. СПб., 1881-1883; Позднеев А.М.



холбоотой бөгөөд тэдгээрийг улсын шууд дэмжлэгтэйгээр явуулсан байдаг. Зах зээл болон худалдааны хэтийн төлөвийг судлах зорилгоор Оросын ажил хэрэгч хүмүүсийн Монголд хийсэн экспедицүүд онцгой байр эзэлдэг. Орост Монгол дахь нийгмийн харилцааг задлан шинжлэх ажлыг А.П.Беннигсен, М.И.Боголепов, А.П.Болобан, Е.Г.Грум-Гржимайло, В.Л.Котвич зэрэг хүмүүс хийжээ.<sup>22</sup>

XIX-XX зууны зааг дээрх тавь гаруй жилийн хугацаанд оросын судлаачдаар дамжин Баруунд Монголын болон Өвөр Азийн талаарх хангалттай, дэлгэрэнгүй мэдээлэл ирж байлаа. Энд Пржевальскийн экспедицийн материалуудыг шинжилгээний аялал бараг дуусангуут л англи хэлнээ хөрвүүлсэн байсныг дурдахад л хангалттай юм. К.Г.Э.Маннергеймын экспедицийн материалууд Финлянд улсын музейн маш үнэ цэнэтэй баялаг болсон бөгөөд Баруун мөн Өвөр Азид экспедицүүдийг бэлтгэн явуулжээ. Тэдгээр нь Свен Гедин, Р.Ч. Эндрюс, Х.Хаслунд-Кристенсен, Николай Рерих нарын нэртэй холбоотой билээ.<sup>23</sup>

Тэр үеийн Оросын болоод барууны судлаачдын шинжилгээнд бүхэлдээ колончлолын нөхцөл дэх дэлхийн байгууламжид Монголын улс төрийн субъектын роль тодорч чадахгүй байсан л даа, гэхдээ дэлхийн их гүрнүүдийн улс төрийн бодлогын объект болохынхоо хувьд энэ орны үүрэг ролийн талаар маш их эмпирик мэдээ материалыг цуглуулсан байсан бөгөөд энэ нь цаашдын судалгаанд зайлшгүй шаардлагатай нөхцөл бүрдсэн хэрэг байв. Эдгээр ажлын онцлог шинж нь Монголыг Өвөр Азийн нийт бүс нутгийн Н.К.Рерихын хэлснээр «Азийн зүрхний» буюу Төв Евроазийн (Оросын, барууны зохиогчдынхоор «харт-лендийн») улс төрийн орон зайтай зайлшгүй холбоотойгоор авч үзсэн явдал юм.

Энэ үед буддын шашны томоохон сэтгэгч, XIII далай ламын эрх ашгийг төлөөлөгч агуу дипломатч, Оросын буриад Агваан Дорж (1853-1938) дэлхий дэх Монгол, Төвдийн байр байдлыг үнэлэх өөрийн үнэлгээтэйгээ онцгой тодорч харагддаг. Түүний зураглан бичсэн тус бүс нутаг дахь геополитикийн хуваарилалт нь өнөөдөр ч ялангуяа 2016 оны 7 дугаар сард Улаанбаатар хотод болсон Ази, Европын 50 гаруй улс орны ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд нарыг монгол гэрийн «эсгий хананы» дотор цуглуулж чадсан АСЕМ-ийн чуулга уулзалтын өнгөн дээр чухал хэвээр байна. 1921 оны Монголын хувьсгалын өмнөхөн Далай ламд бичсэн захидалдаа тэрээр Өвөр Азид явуулах олон талт улс төрийн бодлогыг Энэтхэг,

---

Монголия и монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893гг, А.Позднеевым. Т.1-2. СПб., 1896-1898; Козлов П.К. Монголия и Кам. Трехлетнее путешествие по Монголии и Тибету, 1899-1901.

<sup>22</sup> Беннигсен А.П. Несколько данных о современной Монголии. СПб.: Типография А.С.Суворина, 1912; Боголепов М.И., Соболев М.Н. Очерки русско-монгольской торговли, с приложением 22 фотографий и торговой карты Монголии (Экспедиция в Монголию 1910 г). Т.1.Томск: Изд-во Томского общества изучения Сибири, 1911; Болобан А.П. Монголия в ее современном торгово-экономическом отношении. Отчет агента Министерства торговли и промышленности за 1912-1913 гг. Пг.: Типография В.Киршбаума, 1914; Грумм-Гржимайло Г.Е. Западная Монголия и Урянхайский край. Т.1. Вып. 2: Антропологический и этнографический очерк этих стран. Торговля и колонизаторская деятельность в них китайцев и русских. Дополнения и поправки. Л.: Изд-во Гос. РГО, 1930; Котвич В.Л.Краткий обзор истории и современного политического положения Монголии, СПб.: Картографическое заведение А.Ильина, 1914; Московская экспедиция в Монголию. М.: Типография П.П.Рябушинского, 1912.

<sup>23</sup> Гедин С. Тарим, Лобнор, Тибет. Путешествие по Азии. 1889-1902 / Пер. со швед. СПб., 1904; Эндрюс Р.Ч. Тайны пустыни Центральной Азии // Вестник знания. 1927. №10; Haslund & Christensen H. Men and Gods in Mongolia. Zayagan. L., 1935; Roerich N.K. Heart of Asia. N.Y., 1929.

Хятад болон энэ хоёр оронд байгаа мусульманчуудын, тэрчлэн Англи болоод Оросын байр суурийг харгалзан тооцож боловсруулах зайлшгүй шаардлагатайг тэмдэглэсэн байдаг. «Тэргүүлэгч хүчнүүдтэй тэдэнд зохих сэтгэгдэл төрүүлэхийн тулд»<sup>24</sup> нягт харилцаанд орохын тулд, «урьдчилсан арга хэмжээ» авахын төлөө Агваан Дорж тэмцэж байжээ.

Дэлхий дэх Монголын байр суурийг судлах оросын эрдэмтдийн сонирхол хэвээр байснаар барахгүй Зөвлөлтийн үед улам хөгжсөн юм. Тухайлбал, эрдэм шинжилгээ-судалгааны экспедицүүдийн практикийг цааш нь үргэлжлүүлсэн (Центросоюзын экспедицийн үр дүнгээр 1921 онд И.М.Майскийн «Современная Монголия»<sup>25</sup>, («Орчин үеийн Монгол») гэдэг ном хэвлэгдсэн, мөн П.К.Козловын алдартай экспедиц Монголд 1923-1926 онд явагдсан<sup>26</sup>). Гэвч эдүгээ судлаачдын анхаарал физик газар зүйн болон аж ахуй-эдийн засгийн онцлог шинжтэй Монголд улс төрийн ашиг сонирхлуудын объект гэдгээр нь төдийгүй, мөн хувьсгалт үйл ажиллагаануудын субъект гэдэгт нь цэглэн төвлөрч байна. Тэгэхдээ Өвөр Азийн нүүдэлчдийг эртний марксист уламжлалын үзэл санааны дагуу хувьсгалт хөгжлийн процесст «хоцорсон» угсаатны зүйн «реликт (үндэс болсон эртний) ард түмнүүд» хувиар гэхээсээ илүүтэйгээр<sup>27</sup> «капитализмыг алгасан феодализмаас социализмд шилжих» үзэл баримтлалд илэрхийлэгдсэн социал-туршилтуудын «ажлын материал» гэдгээр нь авч үзэх болжээ.

К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленины бүтээлүүдэд аливаа судалгааны арга зүйн үндсийн хувиар «дээрээс» хүчлэн шахсан зөвлөмжүүдэд тусгагдсан ангич хандлагын ноёрхлын нөхцөлд 70-н жил оршсон Зөвлөлтийн шинжлэх ухааны дэг сургуульд ямартай ч Монголын улс төрийн өнгөрсөн ба одоогийн байдлын талаар янз бүрийн өвөрмөц үзэл бодлууд бүрэлдэн тогтжээ.

Дундад зууны Монголын нийгмийн социал-улс төрийн харилцааны сонгодог судалгааг Б.Я.Владимирцов хийжээ. Түүний хувьд Монголын нийгмийн улс төрийн субъект чанар мэдээж тодорхой байжээ. Зөвлөлтийн монгол судлалын асуудлуудын төвд судлаж буй объектдоо марксист формацийн схемийг хэрэглэх тухай асуудал байсантай холбогдоод Б.Я.Владимирцов энэ схемийн бичвэрт дундад зууны Монголын нүүдлийн нийгмийн социал бүтцийг феодлын хэмээн тодорхойлж үсрэлт хийжээ.<sup>28</sup> Өөрөөр хэлбэл, ингэснээрээ тэрээр нүүдэлч малчдын нийгмийн социал бүтцийг суурин нийгмүүдийн бүтэцтэй соёл, улс төрийн адил үнэ цэнэтэйг тэмдэглэсэн хэрэг болжээ. Владимирцовтой нэг үеийн В.В.Бартольд мөн л сонгодог

<sup>24</sup> «Предание о кругосветном путешествии» или повествование о жизни Агвана Доржиева. Улан- Удэ: БИОН СО РАН, 1994. С 34; Доржиев А. Занимательные заметки: описание путешествия вокруг света (Автобиография) / Пер. с монг. А.Д.Цендиной. М.: Восточная литература, 2003. С. 68.

<sup>25</sup> Майский И.М. Современная Монголия. Иркутск., 1921.

<sup>26</sup> Козлов П.К. Дневники Монголо-Тибетской экспедиции. 1923-1926. СПб.: Наука, 2003.

<sup>27</sup> Формаций онолыг үндэслэгч, Монголыг «соёл иргэншилт ертөнцөөс бин бүтүү тусгаарлагдсан зэрлэг бүдүүлэг» хэмээн үзэж байсан К.Марксын бүтээлүүдэд энэ орныг түүхийн субъектийн хувьд үл тоомсорлосон, үгүйсгэн хандаж байсан нь хангалттай тод харагддаг юм. ( Маркс К. Революция в Китае и Европе // Маркс К., Энгельс Ф. Сочинения. 2-е изд. Т.9. М.: Политиздат, 1957. С. 99).

<sup>28</sup> Владимирцов Б.Я. Общественный строй монголов: монгольский кочевой феодализм. Л.: Изд-во АН СССР, 1934. С. 75-78.

бүтээл болсон өөрийн ажлуудаа Турк, Монголын ард түмнүүдийн байгуулсан төрийн байгууллагуудын түүхийг судлан туурвихад зориулжээ.<sup>29</sup> Энэ хоёр эрдэмтэн хоёулаа ЗСБНХУ дахь Дорно дахины судлалын шинжлэх ухаан бүрэлдэн тогтохын эхийг тавьсан бөгөөд тиймээс өөрсдийн хувьсгалын өмнөх шинжлэх ухааны мэдлэгээ өргөн ашиглах, С.Ф.Ольденбург, Ф.И.Шербатский, В.М.Алексеев зэрэг томоохон, дорно дахины судлаачидтай санал бодлоо чөлөөтэй солилцох, мэтгэлцэх бололцоотой байжээ. «Орчин үеийн» Монголын анхны Зөвлөлтийн судлаач бол дээр дурдсан И.М.Майский байсан (хожим ЗСБНХУ-ын ШУА-ийн жинхэнэ гишүүн болсон, Их Британид ЗСБНХУ-ын элчин сайд байсан). Тэрээр 1918 оны хүн амын тооллогын материалаар болон 1920 оны өөрийн ажиглалтаар Монголын нийгмийн социал бүтэц, үндсэн анги, давхаргуудын хоорондын харилцааг маш нарийн судалсан хүн юм.

1921 оноос Монголд улс төр нийгмийн үндсэн өөрчлөлт эхэлсэн. Тэгэх тэгэхдээ хувьсгалт практик нь үйл явцыг шинжлэх ухаанчаар эргэцүүлэн бодохоос илт түрүүлж байв. Нөхцөл байдлыг задлан шинжлэх ажиллагаа Өвөр Азийн хойт хэсгээс буюу Зөвлөлт Буриадаас ирсэн, Монголын төрийн дээд хэсэгт багтан орсон улс төрийн зүтгэлтнүүдийн, тухайлбал, Коминтерны элч төлөөлөгч Элбэгдорж Ринчино<sup>30</sup>, төрийн зүтгэлтэн, эрдэмтэн Ц.Жамсран<sup>31</sup> нарын гарт байлаа. Монгол зүс царайтай, монгол хэл мэддэг эдгээр идэвхтнүүд европын боловсролтой байсан бөгөөд Орост болж буй большевик маргаан мэтгэлцээний хүрээнд болон Монголд өрнөж ассан улс төрийн үйл явдлуудын гүнд нь нэгэн зэрэг байсан юм. Тэдэнд тодорхой арга зүйн болоод улс төрийн шууд дэмжлэгийг Коминтерн болон БОКН (ВКПб) -ын томоохон улс төрийн зүтгэлтнүүд, тухайлбал, 1921 оны Монголын хувьсгалын «дирижер» Б.З.Шумяцкий үзүүлж<sup>32</sup> байв. Хожим нь А.Д.Каллиников<sup>33</sup>, В.И.Юдин<sup>34</sup>, Г.Ф.Кунгуров, И.А.Сороковиков<sup>35</sup> зэрэг бусад судлаачид гарч ирсэн. Монголын удирдагчид: түшмэлүүд, түүхчид, тухайлбал, Х.Чойбалсан, Г.Дэмид, Д.Лосол<sup>36</sup>, А.Амар<sup>37</sup>, Л.Дэндэв<sup>38</sup>, Б.Ишдорж<sup>39</sup>, Б.Баянчуулган<sup>40</sup>, Н.Магсаржав (Магсар хурц)<sup>41</sup> нар судалгааны ажил хийж байлаа.

<sup>29</sup> См., например: Бартольд В.В. История турецко-монгольских народов // Бартольд В.В. Работы по истории и филологии тюркских и монгольских народов. М.: Восточная литература, 2002. С. 193-232.

<sup>30</sup> Элбек-Доржи Ринчино о Монголии. Улан- Удэ, 1998, Элбек-Доржи Ринчино. Документы, статьи, письма. Улан-Удэ, 1994.

<sup>31</sup> Жамцарано Ц.Ж. Монгольские летописи XVII в. М.- Л.: Изд-во АН СССР, 1936.

<sup>32</sup> Шумяцкий Б.З. Сибирь на путях к Октябрю. Иркутск: Восточно-сиб. кн. изд-во, 1989.

<sup>33</sup> Каллиников А.Д. Национально-революционное движение в Монголии. М., 1926.

<sup>34</sup> Юдин В.И. У истоков Монгольской народной революции. М.: Востлит, 1931.

<sup>35</sup> Кунгуров Г.Ф., Сороковиков И.А. Аратская революция. Исторической очерк. 2-е изд. Иркутск, 1957.

<sup>36</sup> Чойбалсан Х., Дэмид Г., Лосол Д. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсч байгуулагдсан товч түүх. Тэргүүн дэд дэвтэр. Улаанбаатар, 1934.

<sup>37</sup> Амар А. Монголын шинэ түүх. Улаанбаатар, 1989.

<sup>38</sup> Дэндэв Д. Дундад үеийн Монгол түүх. Монголын эх түүх. III боть. Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар, 2015; Дэндэв Д. Монголын товч түүх, Монголын эх түүх. VI боть, Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар, 2015.

<sup>39</sup> Ишдорж Б. Монгол Улсын хураангуй түүх. Монголын эх түүх. II боть. Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар, 2015.

<sup>40</sup> Буянчуулган Б. Манж, Монгол холбогдсон түүхт байдал. Монголын эх түүх. IV боть. Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар, 2015.

<sup>41</sup> Магсаржав Н. Монголын шинэ түүх. Монголын эх түүх. V боть. Соёмбо принтинг ХХК, Улаанбаатар, 2015.

Сүүлийн жилүүдэд Коминтерн, БОКН (ВКПб)-ын өмнө нь хаалттай, нууц байсан архивын материалууд хэвлэгдсэн (ихээхэн хэсэг нь монгол хэлээр орчуулагдан гарсан)<sup>42</sup> бөгөөд тэр нь большевикуудын ажил үйлдлийн лабораторийн нууцуудыг нээж өгсөн юм. Тэнд нь «*дэлхийн хувьсгалын ирээдүйн тулаанд*», өөрөөр хэлбэл, төсөөлөн буй дэлхийн байгууламж дахь Монголын байрыг бэлтгэж байлаа. Энэ байрыг төвлөрсөн хэлбэрээр Коминтерны гүйцэтгэх хорооны гишүүн Сэн Катаяма томьёолон тэмдэглэсэн байдаг. Тэрээр 1925 оны хавар Улаанбаатарт мэдэгдэхдээ: «*Гадаад Монгол Өвөр Монгол руу, Барга руу, Шиньжан руу өөрсдийн хамаатан нэгтнүүд рүүгээ яваг, тэднийгээ бүгдийг нь дэлхийн империализмын эсрэг зохион байгуулаг*»<sup>43</sup> гэжээ. Элбэгдорж Ринчино Монголыг Хятад, Төвд, Энэтхэгт хувьсгалт хөдөлгөөнийг өрнүүлэхийн тулд талбар болгох эрс большевик үзэл санааг хатуу баримталж байв.<sup>44</sup> Цэвээн Жамсран болохоор буддизм нь коммунизмтай адил төстэй тухай, Монгол, Орос, Хятадын монгол ард түмнүүдийн «Швейцарь маягийн»<sup>45</sup> холбооны тухай илүү зөөлөн аядуу санааг хэлж байлаа. Энэ бүхэн нь уг чанартаа дэлхийн хувьсгалын хүрээнд нийт Монголоор Өвөр Азийн улс төрийн цөмийн үүрэг гүйцэтгүүлэх л гэсэн хэрэг байв.

Монгол нь нэгтгэлийн бус, харин нутаг дэвсгэрийн хувьд бүр ХХ зууны эхнээс л Японтой Оросын хийсэн чухал нууц хэлэлцээрүүдийн зүйл болж байжээ. Тэр үед л Монгол болоод түүний эргэн тойрны бүс нутгийг Евразийн төв дэх «*завсрын бамбай бүс*», «*алх дөш*», «*сэндвич*»<sup>46</sup> хоорондын маргаантай нутаг дэвсгэр хэмээн үздэг хуучин, шинэ ертөнцийн уламжлал тавигджээ. 1921 оны хувьсгалын ялалтыг дэлхийн хувьсгал нэг орны хүрээнээс хальж буй анхны практик алхам хэмээн хүлээн авсан ЗСБНХУ-ын дээд удирдлагад, мөн Ерөнхий сайд Танакагийн Меморандумын дагуу<sup>47</sup> Японд Монголын нутаг дэвсгэрийг дэлхийн улс төрийн бодлогын нэн чухал стратегийн газруудын нэг гэж үзэн, түүнд тийм үүрэг ноогдуулж байсан нь сонирхолтой юм. Чухамхүү энэ л суурь дэвсгэр дээр барууны томоохон Монголч эрдэмтэд, дорно дахины судлаачид, тухайлбал, О.Латтимор, Ж.Фритерс, П.Пеллио, Э.Хэниш, А.Мостэрт, В.Хайссиг, Р.Груссэ<sup>48</sup> нар Өвөр Азийн бүс нутгийг үнэхээр нэвтэрхий судлах тэдний ажиллагаа өрнөсөн билээ.

---

<sup>42</sup> Коминтерн ба Монгол. Баримтын эмхэтгэл (Коминтерн и Монголий. Сб. Документов / Сост. Г.М.Адибеков, С.Дамдинсүрэн, А.С.Железняков и др). Улаанбаатар, 1996; Монголын тухай БХК (б) Намын баримт бичигт (Монголия в документах ВКП (б). Т.1 (1920-1932). Сб. Документов / Отв. сост. А.С.Железняков, С.Дамдинсүрэн. Улаанбаатар, 2002. – 560 с.; Монголын тухай БХК (б) Намын баримт бичигт (Монголия в документах ВКП (б). Т.2. (1933-1940). Сб. Документов / Отв. сост. В.Н.Шепелев, С.Дамдинсүрэн. Улаанбаатар, 2005. – 468 с.; Монголия в документах Коминтерна (1919-1934). Ч. I. (1919-1929); Ч. II (1930-1934) / Науч. Ред. Б.В.Базаров. Улан-Удэ, Изд-во БНЦ СО РАН, 2012.

<sup>43</sup> РГАСПИ. Ф. 495. Оп. 152. Д. 45. Л. 31-32.

<sup>44</sup> Элбек-Доржи Ринчино. Документы, статьи, письма. С. 133.

<sup>45</sup> РГАСПИ. Ф. 495. Оп. 152. Д. 119. Л. 203-208.

<sup>46</sup> Ewing T.E. Between the Hammer and the Anvil? Chinese and Russian Policies in Outer Mongolia, 1911-1921, Bloomington, Indiana: Research Institute for Inner Asian Studies, 1980.

<sup>47</sup> Меморандум генерала Танака Гиити (25 июля 1927 г.) // История войны на Тихом океане Т.1. М., 1957. С. 337-353. (Судлаачдын гарт үүнтэй ав адил баримт бичиг байхгүй, тийм учраас Хятадад анх хэвлэгдсэн бичвэрийн жинхэнэ эсэхэд эргэлзээ байдаг, хэдий тийм боловч уг бичвэр тэр цаг үеийн болон Японы дайчидын сэтгэл санааны байдлыг нэлээд нарийн илэрхийлдэг).

<sup>48</sup> Эдгээр зохиолчдын бүтээлээс заримыг дурдаж болно. Lattimore O. The Mongols of Manchuria: Their Tribal Divisions, Geographical Distribution, Historical Relations with Manchus and Chinese and Present Political Problems. N.Y., 1934; Fritters G.M. The International Position of Outer Mongolia. A Contribution to Russia's and Japan's Policies in the Far East // These presentee a l'Universite de Geneve pour l'obtention du grade de Docteur des sciences politiques. Dijon, 1939; Pelliot P. Recherches sur les Chretiens d'Asie central et d, O. P., 1973; Haenisch E. Die

Мэдээж, Монгол болоод Зөвлөлт Орос явагдсан хувьсгалт өөрчлөлтүүдийн жилүүдэд ч үзэл суртлын «*тааруулга*»-д хэлбэрийн хувьд л түшиглэж байсан судалгаа хийгдсээр байлаа. Нүүдэлчний нийгмийн (1920 - 1930-аад оны) орчин үеийн социал бүтцийг А.Д.Симуков, Монголчуудын нийгмийн байгуулал, тэдний дэлхийн дэх түүхэн ролийг Б.Я.Владимирцов нар нэлээд бие даасан байдлаар судалж байжээ. А.Д.Симуковын шинжлэх ухааны өв зөвхөн сүүлийн жилүүдэд л өргөн олон судлаачдын хүртээл боллоо.<sup>49</sup> «*Хуучин шинжлэх ухааны чадвар*»-ыг хадгалж үлдсэн тэр үеийн монгол, буриад судлаачдын дотроос Эрдэнэпил лам<sup>50</sup>, «*буддист бадарчин*», хожмын процессор Г.Ц.Цибиков<sup>51</sup> нарыг дурдах хэрэгтэй.

Хожим нь, дайны дараах жилүүдэд марксист үзэл суртал, арга зүйн санааны дагуу баримт материалыг нэгтгэн дүгнэх ажиллагааг И.Я.Златкин, Б.Ширэндэв, М.С.Капица, С.Д.Дылыков, А.В.Бурдуков нарын зэрэг<sup>52</sup> нэр хүндтэй том судлаачид эрхэлж байлаа. Эдүгээ Орос болон Монголын амьд сэрүүн байгаа судлаачдын үндсэн бүрэлдэхүүний хувьд Монгол дахь улс төрийн процессын агуулгын талыг нь тэд өөрсдөө болон багш нарынхаа үзэл бодлоор дамжуулан тодорхой арга зүйн түлхүүрээр «*марксизмын гурван эх сурвалж, гурван бүрэлдэхүүн хэсгийн*» хүрээнд нээж байлаа.

Судлаачдын нэг хэсэгт маш өвөрмөц тал нутгийн гурамсал зохиолтойгоо болон «*их эрчим*» үзэл баримтлалтайгаа<sup>53</sup> удаан хугацаанд хавчлагад байсан Л.Н.Гумилев тодорхой нөлөө үзүүлсэн<sup>54</sup> билээ. Л.Н.Гумилев бол дайны өмнөх хилийн чанад дахь оросуудаас бүрдсэн шинжлэх ухааны бүхэл бүтэн дэг сургуулийг бүрдүүлэгч евроазичууд (юуны өмнө, П.Н.Савицкий, Г.И.Вернадский, Н.И.Трубецкой болон бусад<sup>55</sup>) -ын үзэл санааны хөтөч байлаа. Евразичууд Монголын эзэнт гүрэн мандан бадарч байсан үеийн түүний субъект чанарыг хүлээн зөвшөөрдөг, гэвч бүр хожмын үед энэ субъект чанарын «*зүүг*» Евразийн хязгааргүй орон зайд төв зангилаа нь болж орсон Орос орон руу «*шилжүүлжээ*».<sup>56</sup> Монголд хандах тийм хандлагын цуурай одоо ч мөн Орос, Монгол хоёр «*нэгдмэл евразийн соёл-газар зүйн ертөнц*»-ийн болон тэр ч байтугай «*нэгдмэл евроазийн хэт (супер)*» угсаатны хүрээнд бие

---

Kulturpolitik des mongolischen Weltreichs. В., 1943; Heissig W. Der mongolische Kulturwandel in den Hsingan Provinzen Mandschukuos. Vienna-Peking, 1944; Mostaert A. The Mongols of Kansu and their Language // Bulletin of the Catholic University of Peking. 1931. No 8; Груссе Р. Чингисхан. Покоритель Вселенной / Послесловие А.С.Железнякова. Серия ЖЗЛ. М.: Молодая Гвардия, 2000.

<sup>49</sup> Симуков А.Д. Труды о Монголии и для Монголии /Сост. Юки Конагая, Санжаасүрэнгийн Баяраа, Ичинхорлоогийн Лхагвасүрэн. Осака: Государственный музей этнологии. Т. 1. 2007; Т.2. 2007; Т.3. Ч.1. 2008; Т. 3. Ч. 2. 2008.

<sup>50</sup> Эрдэнэпил Ж. Конечная причина религий в Монголии. / История в трудах ученых лам. С. 155-247).

<sup>51</sup> Цибиков Г.Ц. Буддист-паломник у святынь Тибета. Т. 1-2. Новосибирск: Наука, 1991.

<sup>52</sup> Златкин И.Я. Очерки новой и новейшей истории Монголии. М.: Вочточная литература, 1957; Капица М.С., Иваненко В.И. Дружба, завоеванная в борьбе. М.: 1970; Ширендыб Б. Монголия на рубеже 19-20 веков. Улан-Батор: Комитет по делам печати, 1963; Бурдуков Н.В. В старой и новой Монголии. Воспоминания и письма. М., 1969; Дылыков С.Д. Демократическое движение монгольского народа в Китае. М.: Изд-во АН СССР, 1953.

<sup>53</sup> Гумилев Л.Н. Хунну. Средняя Азия в древние времена. М., 1960; Он же. Древние тюрки. М., 1967; Он же. Поиски вымышленного царства. М., 1970.

<sup>54</sup> Гумилев Л.Н. Этногенез и биосфера Земли. Л., 1990.

<sup>55</sup> Савицкий П.Н. Континент Евразия. М.: Аграф, 1997; Вернадский Г.В. Указ. соч.; Трубецкой Н.С. История. Культура. Язык. М.: Прогресс, 1995.

<sup>56</sup> Трубецкой Н.С. Наследие Чингисхана. Взгляд на русскую историю не с Запада, а с Востока // Трубецкой Н.С. История. Культура. Язык. С. 211-212.

биедээ татагддагийг заан тэмдэглэдэг оросын нэр хүндтэй зохиогчдын дотор ч сонсогдож байдаг<sup>57</sup>.

Хятадын түүх судлалын асуудлыг задлан шинжлэх явдлыг дараагийн удаад хятадын оролцогчид төсөлд нэгдэн орох үед хийх нь зохистой гэж бодогдоно. Энд тооцоо бол энгийн. Үүнд: БНХАУ-аас Монгол соёл иргэншлийн атласын хамтран зохиогчид асуудлыг хэрхэн харж байгаагаа, сэдвийг боловсруулахад хятадын шинжлэх ухааны байр суурийг үнэлэх хажуугийн үнэлгээг ямар нэгэн байдлаар эргэж харахгүйгээр, өөрөөр хэлбэл «цэвэр хуудас»-наас ажлаа эхлэхээ танилцуулж болно.

Эдүгээ Өвөр Азийн бүс нутгийг түүний нэгдмэл социал бүхэллэгээр нь К.Хамфри, Д.Снит, тодорхой хэмжээгээр С.Загчид, П.Хайер, А.Кампи, У.Булаг, К.Эттвуд зэрэг олон судлаачид судлаж байн.<sup>58</sup> Дэлхийн зарим томоохон их сургуулиудад Өвөр Азийн буюу төв Евразийн бүс нутгийн зарим хэсэгчлэл зохистой болохыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тэр нь эрдэм шинжилгээний төвүүдийн<sup>59</sup> нэрээр илэрч байна.

Орост бүс нутгийн түүх-соёлын асуудлыг бүхэл бүтэн академийн институтийн, тухайлбал, Оросын ШУА-ийн Монгол, Төвд, Буддын шашин судлалын институтийн түвшинд судалж, эрдэм шинжилгээний сэтгүүл<sup>60</sup> гаргаж, атласуудыг<sup>61</sup> боловсруулж, Улаан-Үд болон Москвад олон улсын бага хурал, эрдэм шинжилгээний дугуй ширээний ярилцлагууд<sup>62</sup> зохион байгуулж байна. ЮНЕСКО-ийн ивээл дор Монгол

---

<sup>57</sup> См., например: Иванов А.В. Цивилизационный статус Монголии и ее вклад в укрепление евразийского единства // Монгольский мир: между Востоком и Западом / Под. ред. Ю.В.Попкова и Ж.Амарсаны. Новосибирск: Автограф, 2014. С. 69.

<sup>58</sup> Culture and Environment in Inner Asia / Ed. by C. Humphrey, D. Sneath. Vol. 1: The Pastoral Economy and the Environment. Cambridge: The White Horse Press, 1996; The End of Nomadism? Society, State and the Environment in Inner Asia by Caroline Humphrey and David Sneath. Durham: Duke University Press, 1999; Jagchid S., Hyer P. Mongolia's Culture and Society. Boulder: University of Colorado Press; Karamisheff W. 1925. Mongolia and Western China; Social and Economic Study. Tientsin, 1979; Campi Alicia. Mongolia's Integration Congress of Mongolists being Convened Under the Patronage of N. Bagabandi, President of Mongolia (5-11 August 2002, Ulaanbaatar). Summaries of Congress Papers. Secretariat IAMS, 2002; Where is East Asia? Central Asian and Inner Asian Perspectives on Regionalism by Uradyn E. Bulag. Japan Focus. Posted October 12, 2005. Нийтэлсэн 29.09.2009 // <http://www.unuudur.com/?p=5836>; Is There Such a Thing as Central/Inner (Eur)Asia and Is Mongolia a Part of It? by Christopher P. Atwood — Mapping Mongolia: Situating Mongolia in the World from Geologic Time to the Present. By Paula L.W. Sabloff. Pacific Affairs, 85(3), September 2012.

<sup>59</sup> Inner Asian and Altaic Studies, The Graduate School of Arts and Sciences, Harvard University; The Mongolia and Inner Asia Studies Unit, Department of Social Anthropology, University of Cambridge; The Sinor Research Institute for Inner Asian Studies, School of Global and International Studies, College of Arts and Sciences, Indiana University; Centre for Inner Asian Studies, School of International Studies, Jawaharlal Nehru University, New Delhi, India и др.

<sup>60</sup> Гуманитарные исследования Внутренней Азии – Буриадын улсын их сургуулийн Өвөр Азийн институтын сэтгүүл.

<sup>61</sup> Историко-культурный атлас Бурятии / Науч. ред. Н.Л.Жуковская. М.: ИПЦ «Дизайн. Информация. Картография», 2001 (руководитель научного коллектива – директор Института монголоведения, буддолог-гии и тибетологии СО РАН Б.Б.Базаров); Папуев В.Б. Монгольские народы. Атлас истории и этнографии. Учебное пособие. Элиста., АПП «Джангар», 2005.

<sup>62</sup> Проблемы истории и культуры кочевых цивилизаций Центральной Азии. Материалы международной научной конференции. Т. IV. История, философия, социология, филология, искусство. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2000; Чингисхан и судьбы народов Евразии. Материалы международной научной конференции. 3–5 октября 2002 г., Улан-Удэ: Изд-во БурГУ, 2003; Россия и Монголия в свете диалога евразийских цивилизаций. Материалы международной научной конференции. Звенигород, 2–5 июня 2001 г. М.: ИВ РАН, Общество монголоведов РАН, 2002; «Калмыки и их соседи в составе Российского государства», «Кочевая цивилизация Великой степи: современный контекст и историческая перспектива». — Элиста (2001), Цивилизационные

Улсад үйл ажиллагааны үүнтэй адил хүрээтэй нүүдлийн соёл иргэншлийг судлах Олон улсын институт ажиллаж байна.<sup>63</sup>

Сүүлийн хорин таван жилд Монголын субъект чанарын сэдэв онцгой анхаарлын объект боллоо. Тухайлбал, түүнийг Орос, Монголын болон бусад орны түүхчид, улс төр судлаачид, социологичид, эдийн засагчид, философичид, хэл зүйчид улам их хөндөгчөөж байна. Тэдний дотор Монгол, Орос болон Хятадын хилүүдийн уулзвар дээр өөрийн шинж чанартай соёлын орон зай байдаг, мөн үүнтэй нэгэн зэрэг бүхэлдээ өөрийн хөршүүдээс Монгол соёл иргэншлийн эрс ялгаанд эргэлздэг тийм хүмүүс байхгүй байхаа. Энэ бол Монголын түүх, соёлыг нухацтай судалдаг буурьтай судлаачдын ерөнхий санал бодол юм гэж хэлж болно. Монгол Улсын гадаад улс төрийн бодлогын эрчимтэй өрнөлт, олон улсын харилцааны тогтолцоон дахь түүний өвөрмөц онцгой байдлыг бүхнээс илүү гэрчилж байна.<sup>64</sup>

Гэхдээ 1994 он хүртэл Өвөр Азийн өвөрмөц геополитикийн цөм болох Монгол Улсын идэвхтэй байдлын тухай асуудал буддын шашны өмнөх үе (XVII зуун хүртэлх)-ийн асуудлыг судлах түүхэн судалгаанд хамаардаг. Энэ нь хожим Орос болон Манжийн эзэнт гүрний улсын хил Өвөр Азиар дайран гарсантай, улс төрийн хувьд нэгдмэл түүх, соёл болон социальны контекстыг харгалзан үзэх явдал онцгой хүндрэл бэрхшээлтэй болсонтой холбоотой юм.

Геополитикийн утгаараа тэгж харгалзан үзэх нь Орост ч, Хятадад ч үнэмлэхүй таалагддаггүй панмонгол үзлийн үзэл сурталтай холбоотой байлаа. Гагцхүү 1911-1946 он хүртэлх үе бол нийт бүс нутгийг цогцоор нь улс төр судлалын үүднээс задлан шинжилгээ хийхэд нэн таатай үе юм. Учир нь чухамхүү энэ үед Манжийн болоод Оросын эзэнт гүрнүүдийн сүйрэл болж, тэдгээрийн залгамжлагчид болох Бүгд Найрамдах Хятад улс болон ЗСБНХУ-ын бус нутаг дахь нөлөөний хүрээ нарийвчлагдсан<sup>65</sup> юм. Асуудлыг Орос, Монгол, Хятад болоод бусад орны зүгээс<sup>66</sup> «*өөр дээрээ нөмрөг таталгүй*»-гээр, асуудлыг улс төржүүлэлгүйгээр соёл

---

процессы на Дальнем Востоке. Монголия и ее окружение. Мат-лы научных круглых столов. Ред. коллегия А.С. Железняков, К.Б.-М. Митупов (сопред.), М.Н. Балдано и др. М.: Вост. лит., 2005 и др.

<sup>63</sup> Монголчуудын түүх-соёлын атлас (Историко-культурный атлас монголов)-ыг энэ хүрээлэн бэлтгэсэн. Улаанбаатар: IISNC, 2004, мөн тэрчлэн «Nomads and Use of Pastures Today» сэдвээр олон улсын бага хурал ба симпозиумыг тогтмол хийдэг. Ulaanbaatar, 2000 и др.

<sup>64</sup> См.: Яскина Г.С. Монголия и внешний мир. М.: ИВ РАН, 2002; Хашбат Л. Международный статус Монголии: историко-правовые аспекты. Улаанбаатар, 2001 (В.В. Путин, Ши Жинь Пин, Ц.Элбэгдорж нарын гурван талын уулзалтыг хийж байх Монголын санаачилгатай холбоотой болон Монгол Улсын гадаад улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа эрс өсч буйг гэрчилсэн АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтыг саяхан Улаанбаатарт амжилттай хийсэнтэй холбоотой бүлэг асуудлыг тал бүрээс нь судлах явдал мэдээж ээлжээ хүлээж байна).

<sup>65</sup> Архивын баялаг хэрэглэгдэхүүн дээр түшиглэн бичсэн нэг сэдэвт бүтээлд энэ үед Өвөр Азид болж байсан үйл явцын хүрээнд Монгол Улсын гүйцэтгэж байсан субъектын үүргийг бүрнээ хянамаг зөв авч үзжээ. Лузянин С.Г. Россия–Монголия–Китай в первой половине XX в. Политические взаимоотношения в 1911–1946 гг. М.: ИДВ РАН, 2000.

<sup>66</sup> Агуу тал нутаг, Чингис хааны, Монголын эзэнт гүрний баатарлаг өнгөрсөн үеийн ямар нэг орчин цагийн ард түмэн буюу угсаатны бүлэгтэй холбоотой өвийн асуудлын талаар нилээд их түүх зүйн судалгаа байдаг. Заримдаа хэрэг явдал дэлхий дахины түүхийг дахин сийрүүлэхэд болон шинэ он дарааллыг бий болгоход хүртэл хүргэдэг. Тийм дүгнэлтүүдийн сэдлэгүүд нь гол төлөв зохиогч нарын нь улс төрийн дэврүүн санаархалд оршдог учир зохиол бүтээлүүдийн тухайн хэсэг нь ганц нэгнээс гадна энэхүү судалгааны хүрээний гадна үлдэж байгаа билээ. Бидний үзэж байгаагаар Агуу тал нутгийн өв бол эдүгээ цагт тэнд оршин сууж буй бүх ард түмний баялаг мөн.

иргэншлийн улс төр судлалын дагуу улсын хил хязгааруудын хувьд төвийг сахисан судалгаануудын хүрээнд шийдэхээс өөр замгүй юм.

Судалгааны энэ чиглэлийг нээхэд 1994 онд Монгол Улсын Их Хурлаар баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал чухал алхам болсон<sup>67</sup> юм. Монгол Улс геополитикийн санаархал байхгүйгээ, өөрийн улсын хил хязгаарын гаднах төрөл нэгтнүүд нь оршин суудаг нутаг дэвсгэрүүдийг нэгтгэх ямар ч онцгой зорилго өөрт байхгүйгээ, харин Орос, Хятадын янз бүрийн ард түмнүүдтэй өөрийн хуваалцдаг түүх, соёлын нийтлэг орон зай байдаг тухайгаа зарласан билээ.

Өөрөөр хэлбэл, энд Монгол иргэншил гэдэг нэрийн дор Өвөр Азийн хил дамнасан нэгтгэлийн тухай яригдаж байна. Эргэн тойрондоо хандах тийм харилцаатайгаар л зөвхөн дэлхийн хамтын аж төрөх ёсны дагуу хөршүүддээ тэсвэр тэвчээртэй хандаж, Монголын өөрийн нь Үндэсний аюулгүй байдлын, тэрчлэн Өвөр Азийн хувь заяаг болон түүний соёл иргэншлийг шийдвэрлэхэд татагдан ордог орнууд болох Орос, Хятадын эрх ашгийг хөндөх эрсдэлээс зайлсхийж болно. Атлас дээр ажиллаж буй эрдэмтдийн олон улсын хамтлаг эдгээр эрх ашгийг харгалзан үзэх, дээд зэргээр тэнцвэржүүлэх зорилготой юм.

---

<sup>67</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. – Ардын эрх. 1994, 7 дугаар сарын 26.



Гурав. Суурь судалгааны төслийн хүрээнд хийгдсэн ажил, явцын үр дүн, үр дүнгээс гарсан дэвшилтэт талууд

Судалгааны багийн гишүүд, түүний удирдагчийн зүгээс суурь судалгааны төслийн ажлыг хэрэгжүүлэх календарьчилсан төлөвлөгөөг нарийвчлан шинэчлэн боловсруулж баталсан. Чингэхдээ, салбарын нийт эрдэм шинжилгээний ажилтнуудын эрдэм шинжилгээний жилийн ажлын төлөвлөгөөнд тусгайлан заасан даалгавраар гүйцэтгэх ажлыг үүрэгжүүлсэн нь эл төслийг амжилттай хэрэгжихэд чухал ач холбогдолтой болсон.

Төслийн удирдагчийн хувьд ШУТС-д тухай бүр суурь судалгааны төслийн явцын тайланг хүлээлгэн өгч, үр дүнг тайлагнаж ирсэн. Мөнхүү суурь судалгааны төлсийн зорилтын хүрээнд, багийн гишүүд дараах бодит нөхцөл байдлыг таван үндсэн хэсэгт ангилан шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлон судалсан нь эл судалгааны дэвшилтэт тал болно. Үүнийг тодруулбал,

Зураг 1. Үр дүнгийн даалгаварын хүрээнд нийлүүлсэн бүтээгдэхүүн (ангилал бүрээр)

2019	ЭШИ (гадаад)	1	
	Хээрийн судалгаа	6 аймаг	600 респондент
			6 бүлгийн ярилцлага
			6 ганцаарчилсан ярилцлага
2020	ЭШӨ (гадаад)	5	
	ЭШӨ(дотоод)	1	
2021	ЭШӨ (гадаад)	2	
	ЭШИ (дотоод)	2	
	Хотын судалгаа	6 дүүрэг	400 респондент
			60 экспертийн судалгаа
	Судалгааны тайлан	1	Хээрийн судалгааны нэгдсэн тайлан
	Орчуулгын бүтээл	1	
2022	ЭШИ (гадаад)	3	
	ЭШӨ (гадаад)	1	
	Хамтын бүтээл	1	
	Зурагт цомог	1	
	Товхимол	1	Эмпирик болон тоон судалгааны үр дүнд тулгуурласан судалгааны товхимол

2020 он (2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 2020 оны 12 дугаар сарын 25)-д төслийн багийн гишүүд Евразийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох судалгааны арга зүй, концепцийг боловсруулах, энэ чиглэлээр мэдээлэл, лавлагааны тойм боловсруулж бэлтгэх, шинжээчдийн судалгааг (онлайн болон

хээрийн судалгааны хэлбэрээр) зохион байгуулж, улмаар мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийж, үр дүнг нэгтгэн тайланг боловсруулж бэлтгэв.

Хамтарсан төслийн судалгааны зорилго нь Евразийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох явдал юм. Түүнчлэн төслийг хэрэгжүүлэх явцад Оросын болон Монголын соёл иргэншлийн түүх, орчин үеийн байдал гүнзгий, илт тод илэрнэ. Евразийн интеграцийн хүрээнд олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгохын тулд хоёр орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжилд тулгараад буй асуудлуудыг тодруулах нь тус төслийн зорилго оршино.

2020 онд төслийн багийн гишүүд Евроазийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох судалгааны арга зүй, концепцийг боловсруулах, энэ чиглэлээр мэдээлэл, лавлагааны тойм боловсруулж бэлтгэх, шинжээчдийн судалгааг (онлайн болон хээрийн судалгааны хэлбэрээр) зохион байгуулж, улмаар мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийж, үр дүнг нэгтгэн тайланг боловсруулж бэлтгэсэн болно.

Доорх хүснэгтээр 2020 онд хамтарсан төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөө, таамаглалыг багтаан танилцуулав.

Д/д	Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил үүргийн жагсаалт	Эхлэх дуусах хугацаа (он, сар)	Гүйцэтгэгчдийн овог, нэр	Тухайн шатны үр дүн
1	Евроазийн интеграцийн процессын хүрээнд хоёр орны хоорондох соёл иргэншлийн харилцан үйлчлэлийн хамгийн сайн арга замыг тодруулж Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох судалгааны арга зүй, концепцийг боловсруулах	2020.04.01 - 2020.04.30	Г. Чулуунбаатар, төслийн удирдагч  Багийн гишүүд: С.Чулуун Б.Пүрэвсүрэн	Евроазийн интеграцийн процессын талаарх онол, тодорхойлолт гаргах, баримт бичиг дээр шинжилгээ хийж, тодорхойлолт гарна.
2	Евроазийн интеграцийн хүрээнд олон улсын үр өгөөжтэй хамтын ажиллагааг бий болгохын тулд хоёр орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжилд тулгараад буй асуудлуудыг тодруулах зорилгоор олон улсын болон орон нутгийн статистик, баримт бичигт дүн шинжилгээ хийх, гадаад материалаас орчуулга хийх Судалгааны арга зүй, концепци, судалгааны	2020.04.15 - 2020.05.10	О.Хатанболд Ц.Цэцэнбилэг Ц.Энхчимэг О.Хатанболд Б.Ариунзул А.Хишигдаваа	Уг сэдвээр хийгдсэн судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн гарна.

	хэрэглэгдэхүүнийг боловсруулах			
3	Өрнөдийн ба Өрнөдийн бус орнуудын нийгэм-улс төрийн системд тохиолддог томоохон хандлагууд, өөрчлөлтүүдийн талаарх асуудлыг судлан тодруулж судалгаа-лавлагааны тойм бэлтгэх	2020.05.10 - 2020.06.05	О.Хатанболд, төслийн зохицуулагч  Төслийн багийн гишүүд: А.Хишигдаваа Ц.Цэцэнбилэг Ц.Энхчимэг Б.Ариунзул	Төслийн завсрын үр дүнг нэгтгэх, судалгааны ажлын хүрээг тодорхойлж цаашид хийгдэх судалгаа-шинжилгээний төлөвлөгөө боловсруулна.
4	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын тайлан бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх	2020 оны 6 сард	О.Хатанболд, Төслийн зохицуулагч  А.Хишигдаваа Багийн гишүүн	Явцын тайлан
5	Шинжээчдийн судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах, туршилт хийх: Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнийг турших, эцэслэх	2020.04.25 - 2020.05.15	Г.Чулуунбаатар, Төслийн удирдагч  О.Хатанболд, Төслийн зохицуулагч  <i>Төслийн багийн гишүүд:</i> Ц.Цэцэнбилэг Ц.Энхчимэг А.Хишигдаваа Б.Ариунзул	Судалгааны найдвартай байдал хангагдана.
6	Орос-Монголын улс төр, нийгэм-улс төрийн хөгжлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох хээрийн судалгааг зохион байгуулж мэдээлэл цуглуулах	2020.06.01 - 2020.07.25	Г.Чулуунбаатар, Төслийн удирдагч О.Хатанболд, Төслийн зохицуулагч  <i>Төслийн багийн гишүүд:</i> С.Чулуун Б.Пүрэвсүрэн Ц.Цэцэнбилэг Ц.Энхчимэг А.Хишигдаваа Б.Ариунзул	Анхдагч мэдээлэл цугларна.
7	Хээрийн судалгааны мэдээлэл шивэх, нэгтгэх, хянах	2020.07.25 - 2020.08.20	О.Хатанболд, Төслийн зохицуулагч  <i>Төслийн багийн гишүүд:</i> Ц.Цэцэнбилэг А.Хишигдаваа Б.Ариунзул	Мэдээллийг шалгаж сан үүсгэнэ.
8	Мэдээлэлд шинжилгээ хийх, үр дүнг боловсруулах	2020.08.20 - 2020.09.10	Г.Чулуунбаатар, Төслийн удирдагч О.Хатанболд, Төслийн зохицуулагч  Ц.Цэцэнбилэг Ц.Энхчимэг А.Хишигдаваа Б.Ариунзул	Судалгааны анхдагч үр дүн бий болно.

9	Судалгааны үр дүнгээр гадаад, дотоодын имфактор өндөртэй болон рецензи бүхий хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлд хэвлүүлнэ.	2020.09.15 - 2020.12.10	Г.Чулуунбаатар, Төслийн удирдагч О.Хатанболд, Төслийн зохицуулагч  <i>Төслийн багийн гишүүд:</i> С.Чулуун Б.Пүрэвсүрэн Ц.Цэцэнбилэг Ц.Энхчимэг А.Хишигдаваа Б.Ариунзул	Судалгааны анхдагч үр дүнг эрдэмтдийн дунд хэлэлцэн баталгаажуулна.
10	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын тайлан бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх	2020 оны 12 сард	Г.Чулуунбаатар Төслийн удирдагч О.Хатанболд Төслийн зохицуулагч	Явцын тайлан

## 2. БАГИЙН БҮРЭДДЭХҮҮН

Багийн гишүүний албан тушаал	Овог нэр	Албан тушаал
<i>Төслийн удирдагч</i>	Г.Чулуунбаатар	ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, академич
<i>Төслийн судалгааны багийн гишүүд, үндсэн судлаачид</i>	С.Чулуун	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, академич
	Б.Пүрэвсүрэн	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч, доктор (PhD) дэд профессор
	Ц.Энхчимэг	ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга
	Ц.Цэцэнбилэг	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор (PhD), дэд профессор
	Б.Ариунзул	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Шашин судлалын салбарын ЭШДЭА, докторант
А.Хишигдаваа	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын ЭШДЭА, докторант	
<i>Төслийн зохицуулагч, багийн үндсэн гишүүн</i>	О.Хатанболд	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын ЭШДЭА, доктор (PhD)
<i>Судалгааны багийн гишүүдийн үүрэг хариуцлага</i>	<b>1. Судалгааны багийн удирдагчийн ерөнхий үүрэг хариуцлага</b> 1. Судалгааны багийг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангана. 2. Судалгааны багийн гадаад, дотоод харилцааг тогтоож хэрэгжүүлнэ. 3. Судалгааны ажлын зорилго, зорилтуудыг хангахад багийн гишүүдийн ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. 4. Судалгааны багийн үйл ажиллагааны санхүүгийн менежментийг хариуцна. 5. Төслийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж, судалгааны ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, ажлын үр дүнг тооцож, эцсийн үр дүнг захиалагчийн өмнө хариуцна.	
	<b>2. Судалгааны багийн гишүүд, үндсэн судлаачдын үүрэг, хариуцлага</b> 1. Судалгааны багийн ахлагчийн удирдлаган дор ажиллаж, багийн ажлын хуваарийн дагуу ногдсон ажил үүргийг чанартай гүйцэтгэнэ. 2. Судалгааны багийн ахлагчид ажлаа тайлагнаж, багийн өмнө хамтын хариуцлага хүлээнэ. 3. Судалгааны ажлын арга зүй, аргачлалын талаар санал зөвлөмж гаргах багаар ажиллах, 4. Судалж буй асуудлын хүрээнд тодруулах шаардлагатай зүйлийн талаар лавлагаа мэдээлэл боловсруулах, мэдээллийн дата үүсгэх, багийн зөвлөлдөх уулзалтад тогтмол оролцох, 5. Судалгааны үнэлгээ, дүгнэлтийг бодитой, үнэн зөв гаргаж, судлаачийн ёс зүйг мөрдөн ажиллана. 6. Судалгааны тайлантай танилцаж судалгааны зорилго онолын хийгээд практикийн зорилго, зорилт хангасан эсэх, мэргэжлийн үг хэллэгийн утга	

санааг зөв хэрэглэсэн эсэхэд үнэлэлт өгч, шаардлагатай зүйлсэд засвар оруулах.

2020-2021 онд төслийн хүрээнд «Монголын соёл иргэншлийн дүр царай» зурагт цомгийг боловсруулах ажлын хүрээнд онолын суурь үндэслэгээний онолын судалгааны болон практик судалгааны үр дүнг нэгтгэсэн Монголчууд болон Өвөр Азийн бусад ард түмнүүдийн хувьд нийтлэг өвөг дээдэс чухам хэн бэ? Тэд бол Ази Европын асар том орон зайгаар хүрээлэгдсэн Өвөр Азийн өргөн уудам бүс нутагт амьдрал цогцлоосон нүүдэлчдийн эзэнт гүрнийг үндэслэгчдийн аж төрөх орчин нөхцөлөө бүрдүүлэх, эх орныхоо аюулгүй байдлыг хангах арга ухаан чухамдаа цаг үргэлж л өвөг дээдсээсээ авч байсан арга ухааныг тодруулах зорилгод хөтлөгдсөн.

Энэ хугацаанд нүүдэлчдийн соёл иргэншлийг тал бүрээс нь судалж философийн онтологи, ерөнхий социологи, улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр ОХУ-ын төслийн багийн ахлагч, доктор, профессор А.С.Железняковын туурвисан “Монгол соёл иргэншил: түүх ба орчин үе” нэгэн сэдэвт бүтээлийг эх хэлнээ хөрвүүлэн нийтэлсэн. Эл бүтээлд монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн судалгаа болон орчин үеийн дэлхий дахины, бүс нутгийн иргэншил хоорондын харилцан үйлчлэлийн асуудлыг судлахад арга учир холбогдол бүхий үндсэн ойлголт, нэр томъёог нарийвчлан тодруулах, нэг мөр ойлгож хэрэглэхэд тус болохуйц онол, арга зүйн чиг баримжаа болж чадах нотолгоо тайлбаруудыг дэлгэрэнгүй багтааснаараа онцлогтой.

**МОНГОЛЫН УРСАМ ШИНЖЛЭХ ГАГААРЫН АКАДЕМИ**  
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

Чингис хааны музей

**НОМЫН НЭЭЛТЭНД УРЬЖ БАЙНА**

**МОНГОЛ СОЁЛ ИРГЭНШИЛ**  
ТҮҮХ БА ОРЧИН ҮЕ  
А.С. ЖЕЛЕЗНЯКОВ

**А.С.Железняков**  
ОХУ-ын ШУА-ийн Социологийн хурьцангуйн Улс төр судлал, улс төрийн социологийн төвшин удирдагч, Улс төрийн шинжлэх ухааны доктор, ЭШТА

Цахим хэлбэс:  
[meet.google.com/xnm-qeup-asn](https://meet.google.com/xnm-qeup-asn)

**МОНГОЛЫН УРСАМ ШИНЖЛЭХ ГАГААРЫН АКАДЕМИ**  
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

Чингис хааны музей

**ШУА-ийн Философийн хүрээлэнгээс эрхлэн гартсан А.С.ЖЕЛЕЗНЯКОВЫН «Монгол соёл иргэншил: түүх ба орчин үе» (Атласын онолын үндэслэлээ)**

**НОМЫН НЭЭЛТ**  
Чингис хааны музейн 7 давхарт  
2022.03.16-ны өдрийн 14.30 - 16.00

**ХӨТӨЛБӨР**

Модератор: О.Хатанболд, төслийн зохицуулагч, ФХ-ийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), ЭШТА

Нээлийн үе: Б.Пурвжсүрэн, ФХ-ийн захирал, доктор (Ph.D), профессор

Зөвлөхийн үе: А.С.Железняков, ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэнгийн Улс төр судлал, улс төрийн социологийн төвшин удирдагч, улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, ЭШТА

Рөлхөрийн үе: Г.Чулуунбаатар, Төслийн удирдагч, ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич

Орчуулагчийн үе: Ч.Даваадан, орчуулагч, доктор (Ph.D), профессор

Уншлагчийн төлөөлөл: Б.Батгомьор, УИХ-ын гишүүн, УИХ-ын Ажлаагүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, доктор (Ph.D), Б.Сүргэлэн, Соёлын яамны Соёл, урлагийн бодлогын хэлтсийн дарга

Асуул, гаруул  
Хяамцүүл, сонгодог

Цахим хэлбэс:  
[meet.google.com/xnm-qeup-asn](https://meet.google.com/xnm-qeup-asn)



Энэхүү зургын цомгоор 20 гаруй зууны тэртээд бий болж, өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн соёл иргэншлийн голомт, цөм болох Монгол Улсын талаар танилцуулах болно. Монгол улс бол цөөн хүн ам бүхий орон боловч өөрийн хэмжээнд тэнцвэртэй бус дэлхийд алдартай хүмүүсийг - их гүрнүүдийн (шанью хаан зэрэг) захирагчид, цэргийн удирдагчид, дипломатчид, түүх бичээч, шашны зүтгэлтнүүд, сэтгэгчид, зураачид зэргийг төрүүлсэн. Энэ хүмүүс түүхийг бүтээж, дэлхийн ихэнх хэсэгт аюулгүй байдал, харилцаа холбооны орон зайг бий болгож, Төвд дахь Гелүгийн урсгалын сургаалийг дэлхийн шашин болгон өөрчлөх эх сурвалжийн эхийг тавилцаж, дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүд, бичгийн дурсгалуудыг туурвиснаараа алдаршсан болно. *Зохиогчид: Чулуунбаатар Г., Железняков А.С., Хатанболд О., Ундрал Ё., Гэрэл зурагчид: Цацралт С., Эх бэлтгэл, хэвлэлтийг хариуцсан: «Соёмбо принтинг» ХХК. Уб., 2023. 32.6 хх (хэвлэлтэд)*


Дээрх үндэслэлийг тодруулах үүднээс шинжлэх ухааны үндэслэлийг цогцоор нь гаргах тодорхой зорилго тавьж, тэрхүү зорилгоо бүрэн хэрэгжүүлэх үүднээс «Монгол соёл иргэншил: түүх ба орчин үе (Атласын онолын үндэслгээ)» сэдэвт бүтээлийг орос хэлнээс монгол хэлнээ хөрвүүлэх ажлыг 2020-2021 (2021 оны 8 дугаар сар хүртэлх хугацаа) онд гүйцэтгэж 2021 онд эл нэгэн сэдэвт орчуулгын бүтээл (А.С.Железняков, ред. Чулуунбаатар Г., Хатанболд О., Оюунаа Ц. Уб., 2021, “Соёмбо принтинг” ХХК)-ийг хэвлэн гаргасан.

Энэхүү бүтээлд нүүдлийн иргэншил бүхий Монголчуудыг “бүдүүлэг”, “зэрлэгүүд” байсан мэтээр ярьж бичдэг тал бийг угтаа тэд соёлын тэр дундаа улс төрийн соёлын онцлог хэрнээ аугаа уламжлалтай ард түмэн билээ. Монголчууд бидний уламжлалт улс төрийн соёл нь тал нутагтаа нүүдэллэн мал сүргээ адгуулан аж төрж, төр улсаа төвхнүүлж ирсэн түүхэн үйл явцтай нягт холбоотой байснаараа өрнийн суурин иргэншил соёлоос ялгагддаг.

Монгол хүн аливаад хэрсүү холч ухаанаар уужуу тайван ханддаг, эв эеийг эрхэмлэдэг, төрд хандах хандлага нь тогтсон үнэт зүйлс-ёс суртахууны үнэлэмж бүхий байжээ гэж хэлж болно. Монголчуудын төр ёсны сэтгэлгээ тал нутгийн нүүдэлчдийн сэтгэхүй, үзэл бодол, хамтран аж төрөх, ёс заншлаас уг сурвалжтай билээ.

Монголчуудын улс төрийн соёлын илэрлийн нэг онцлог нь ёс суртахуун, зан заншил нүүдэлчдийн хамтаар аж төрөх өвөрмөц байдлаас үүдсэн хамтач харилцааг зохицуулах үнэлэмж юм. Эдүгээ цагт монголчуудын уламжлалт нүүдлийн соёл, суурин соёлын хүчтэй түрэлтэнд орж, нийслэл Улаанбаатар хотдоо хүн амын бараг тал хувь нь ажиллаж амьдарч байна.

Монголын өнөөгийн улс төрийн өөрчлөлт хувьслын сонирхолтой үедээ ороод байна. Үүнтэй уялдан улс төрийн соёлын хүрээнд шийдвэрлэж хариу өгвөл зохих олон асуудал хуримтлагдаж байна. Иймд иргэдийн улс төрийн соёлын өөрчлөлт, шинэчлэлт, төлөвшлийн хүрээний асуудлыг нарийвчлан судлаж хариу өгөх нь нэн чухал билээ.



Нүүдэлчдийн соёл иргэншлийг тал бүрээс нь судалж философийн онтологи, ерөнхий социологи, улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр бичсэн олон бүтээл зөвхөн монгол, оросын төдийгүй олон улсын хэмжээний эрдмийн хэлэлцүүлэгт аль хэдий нь орсон байдаг. Эл бүтээлд монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн судалгаа болон орчин үеийн дэлхий дахины, бүс нутгийн иргэншил хоорондын харилцан үйлчлэлийн асуудлыг судлахад арга учир холбогдол бүхий үндсэн ойлголт, нэр томъёог нарийвчлан тодруулах, нэг мөр ойлгож хэрэглэхэд тус болохуйц онол, арга зүйн чиг баримжаа болж чадах нотолгоо тайлбаруудыг дэлгэрэнгүй хийжээ. Энэ бол дорно дахин, ялангуяа монголын соёл иргэншлийн давтагдашгүй онцлогийг шинжлэх ухааны арга зүйн оновчтой хандлагаар судлах эрэл хайгуул идэвхтэй өрнөж буй өнөө үед өндөр төвшний мэргэжлийн судлаачийн дагнасан судалгааны үр дүнд тулгуурласан ул суурьтай үзэл баримтлал болж судалгааны эргэлтэд орж байгаагаараа ихээхэн үнэ цэнтэй юм. Бүтээл 6 бүлэг, 14 зүйл, дүгнэлт, зөвлөмж, товч хураангуй, ном зүйн хэсгээс бүрдэнэ.

Бүтээлд монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн судалгаа болон орчин үеийн дэлхий дахины, бүс нутгийн иргэншил хоорондын харилцан үйлчлэлийн асуудлыг судлахад арга учир холбогдол бүхий үндсэн ойлголт, нэр томъёог нарийвчлан тодруулах, нэг мөр ойлгож хэрэглэхэд тус болохуйц онол, арга зүйн чиг баримжаа болж чадах нотолгоо тайлбаруудыг дэлгэрэнгүй хийснээрээ онцогтой.

Энэ бол дорно дахин, ялангуяа монголын соёл иргэншлийн давтагдашгүй онцлогийг шинжлэх ухааны арга зүйн оновчтой хандлагаар судлах эрэл хайгуул идэвхтэй өрнөж буй өнөө үед өндөр төвшний мэргэжлийн судлаачийн дагнасан судалгааны үр дүнд тулгуурласан ул суурьтай үзэл баримтлал болж судалгааны эргэлтэд орж байгаагаараа ихээхэн үнэ цэнтэй юм.



Орчин үеийн нийгмийн хөгжлийн хандлагыг илэрхийлж буй олон хүчин зүйлийн дотор ёс суртахууны боловсролын үүрэг, ач холбогдлын асуудал чухал байр суурь эзлэх болжээ. Иргэдэд ёс суртахууны ухамсар төлөвшүүлэхэд, нийгмийн ёс суртахууныг сайжруулахад ёс суртахууны боловсрол чухал ач холбогдолтой болсоор байна. Өнөө үед ёс суртахууны боловсролын агуулга, чанар, үр дүнгийн асуудал нь манай нийгэмд тулгамдсан асуудлын нэг болжээ. Манай судалгааны баг Монголын ерөнхий боловсролын сургуульд олгож буй ёс суртахууны боловсролын өнөөгийн байдал, тэр нь сурагчдын ёс суртахууны төлөвшилд хэрхэн нөлөөлж байгааг, мөн ёс суртахууны боловсрол төлөвшил олгоход сургалтын орчин, материаллаг бааз, сургалтын хэрэглэгдэхүүний чанар, хүртээмж ямар байгааг тодруулан гаргав. Бүтээл 6 хэсэг, 6 хавсралт, өмнөтгөл, ном зүй хэсгээс бүрдэнэ. *Хэвлэсэн газар: «Соёмбо принтинг». ХХК. Уб., 2022, 11.37 хх. Эрхэлсэн: Улс төр, эрх зүйн салбар, Философийн хүрээлэн, зохиогчид: О.Хатанболд, Ц.Жаргал, М.Золзаяа, Р.Дарьхүү ба бусад. Редактор: Дарьхүү Р, Хатанболд О.*

2022 оны 1 сар – 2022 оны 4 сарын хооронд шинжээчдийн асуулга болон нийслэлийн иргэдийн дунд олон нийтийн санаа бодлын судалгааг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд судалгааны анкет-хэрэглэгдэхүүнийг боловсруулан цахим (Google form)-аар хийж гүйцэтгэв. Тоон мэдээллийн судалгаа боловсруулах ажлын үр дүнд нийтдээ Шинжээчдийн судалгааг (70) 2022 оны 1-2 сард авч, нийслэлийн иргэдийн судалгааг (330) 2022 оны 3-4 сард авч дууссан. Мөн 2022 оны 5 дугаар сараас 6 дугаар сарыг дуустал тухайн цуглуулсан мэдээлэлд шинжилгээ хийж, судалгааны тайланг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Судалгааны тайланд хот, хөдөөгийн иргэдийн дунд (926) хийсэн судалгаа, шинжээчдийн (70) судалгааны дүн багтсан болно (Хавсралт 1, 2-ыг үзнэ үү).



Олон нийтийн судалгаа «МОНГОЛ, ОРОСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, И...

Questions Responses 40 Settings Total points: 0

Section 1 of 6

## «МОНГОЛ, ОРОСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН АМЬДРАЛ» ОЛОН НИЙТИЙН СУДАЛГАА

Form description

Email \*

Valid email address

This form is collecting email addresses. [Change settings](#)

After section 1 Go to section 1 («МОНГОЛ, ОРОСЫН ХА... НИЙТИЙН СУДАЛГАА») ▾

Шинжээчийн асуулга «МОНГОЛ, ОРОСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИ...

Questions Responses 61 Settings Total points: 0

Section 1 of 8

## «МОНГОЛ, ОРОСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН АМЬДРАЛ» ШИНЖЭЭЧИЙН АСУУЛГА

Эрхэм хүндэт Таны амрыг эрье! ШУА-ийн Философийн хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэнтэй хамтран «Монгол, Оросын хамтын ажиллагаа, нийгмийн өнөөгийн амьдрал»-ыг тодорхойлох зорилготой судалгааг зохион байгуулж байна. Энэхүү судалгааны үр дүнг нэгтгэсэн байдлаар ашиглах бөгөөд Таны мэдээллийн нууцлалыг сайтар хангах тул асуулгад идэвхтэй оролцож үнэн зөв хариулт өгөхийг хүсье. Та санал бодлоо илэн далангүй чөлөөтэй илэрхийлнэ үү.

Email \*

Valid email address

This form is collecting email addresses. [Change settings](#)

After section 1 Continue to next section ▾


Дээр дурдсан агуулгын хүрээнд төслийн судалгааны багийн гүйцэтгэгчид «Евразийн түншлэлийн нөхцөл байдал дахь Монгол, Оросын соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэл» (ШуГх/ОХУ/-2019/04)» суурь судалгааны төслийн хүрээнд гүйцэтгэсэн болон нийлүүлсэн бүтээгдэхүүний жагсаалтыг (Хавсралт 1), техникийн ажлын даалгаварын биелэлтийг (Хавсралт 2)-оос тус дэлгэрүүлэн үзэж болно.

Монголын улс төрийн амьдрал, үйл явцын мөн чанарыг зөв бодитой ойлгож төсөөлөх болон сонголт хийх чадвар дээшлэх учиртай. Түүнчлэн улс төрийн оролцооны хууль ёсны хэлбэрийг зохистой хэрэгжүүлэх соёлд суралцах, улс төрийн шийдвэр хэрэгжих боломж дээшилж, ардчилсан тогтолцоо төлөвших, иргэний нийгэм бэхжих зэрэгт эергээр нөлөөлөх үр дүн гаргах болно.

Иргэдийн улс төрийн ухамсар, соёл, ёс суртахуун дээшлэн, тэдний улс төрийн зөв сонголт хийх, ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн идэвхтэй оролцоог хэрэгжүүлэх үйл явцыг боловсронгуй болгох ач холбогдолтой юм. Тодруулбал, иргэдийн ухамсарт ардчиллын үзэл санааны үнэт зүйлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, анархизм руу чиглэсэн үйлдлүүдийг хууль эрх зүйн зохистой бодлогоор хазаарлан барих явдал нийгмийн сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх ач холбогдолтой.

Улс төрийн үйл явцад оролцож буй субъектуудын улс төрийн соёлын төлөвшил нь үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх, төрт ёсоо хүндэтгэх, ардчилал шударга ёсыг бэхжүүлэхэд чухал хүчин зүйл болж буйгаараа ихээхэн анхаарал татаж буй юм. Энэ бүхэн улс төрийн соёлын төлөвшлийн үйл явцыг тусгайлан судлах шаардлага хэрэгцээг нөхцөлдүүлдэг жамтай.



1. Khatanbold O, Chuluunbaatar G. «**Maturation of Political Culture in Mongolia: Its Roles and Effects (Analysis of qualitative research)**». Organized by the "Мир Центральной Азии-V". посвященной 100-летию Института монголове­дения, буддологии и тибетологии СО РАН. 2022.



2. Хатанболд О. «Монголын улс төрийн үйл явцын өнөөгийн байдал: Ардчиллын хөгжил дэх сорилт». ЭШИ. “Зүүн Европын улс орнууд болон Монголын ардчилал: ололт, амжилт, сорилт бэрхшээл” сэдэвт ОУЭШБХ. Философийн хүрээлэн, Монгол Улс дахь Унгар улсын ЭСЯ. 2022 оны 5 дугаар сар. Улаанбаатар хот, Монгол Улс.

12:35 – 13:00 ✓	“Чехословакийн задраагас хойших Чехийн улс төрийн нөхцөл байдал” Д.Энхжаргал МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар Европ судлалын тэнхимийн дэд профессор, Доктор(Ph.D)
13:00 – 13:30	“Монгол болон Европын социалист орнуудын улс төр ба эдийн засгийн шинжилгэйн үеийн харьцуулсан судалгаа” Б.Цогтгэрэл МУИС-ийн багш, Дэд профессор
